

Гэнэтийн ослын даатгалын андрайтингийн гарын авлага

10/30/2014

Хөгжүүлэгчид:

- Аймурат Ээдгээ
- Мөнхсайхан Дамдинсүрэн
- Мөнхсүвд Мөнгөнбаяр
- Наранбаатар Бат-Орших
- Цацрал Цэрэндагва
- Саруул Гонгор
- Одонтуяа Бадамсүрэн

Агуулга

1. ГАРЫН АВЛАГЫН ЗОРИЛГО
 - a. Үндсэн зарчмууд
2. ДААТГАЛЫН БАТАЛГАА
 - a. Тодорхойлолт
 - b. Даатгалын хамгаалалтын хэмжээ
 - c. Өөрийн хүлээх хариуцлага
 - d. Гэрээний ерөнхий нөхцөлүүд
 - e. Бусад тусгай даатгалын бүтээгдэхүүн
3. ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ЖУРАМ
 - a. Цуцлах нөхцөл
 - b. Анхааруулга, мэдэгдэл
4. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ НӨХЦЛҮҮД
5. ЕРӨНХИЙ ХАСАЛТУУД
6. ЭРСДЭЛИЙН БҮЛГҮҮД
 - a. Мэргэжлийн бүлэг
 - b. Хувь хүний сонирхолын бүлэг
7. ХУРААМЖИЙН ТООЦОХ ПАРАМЕТРУУД
8. ХУРААМЖИЙН ТООЦОХ АРГАЧЛАЛ
9. ХӨНГӨЛӨЛТ

ХАВСРАЛТУУД:

10. БАТАЛГААНЫ МАЯГТ
11. НӨХӨН ТӨЛБӨРИЙН МАЯГТ
12. НӨХӨН ТӨЛБӨРИЙН БАРИМТУУДЫН ЖАГСААЛТ
13. СТАТИСТИК МЭДЭЭНИЙ ФОРМАТ
14. ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮЙ МОНИТОРИНГ
15. НӨӨЦ БҮРДҮҮЛЭЛТ
16. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АКТУУД

1. ГАРЫН АВЛАГЫН ЗОРИЛГО

Уг гарын авлагын зорилго нь Монголын даатгалын компаниудын мэргэжилтнүүдийн мэдлэг, чадварыг дээшлүүлж тэдний өдөр тутмын үйл ажиллагааг хөнгөвчлөх юм. Уг гарын авлагыг ашигласнаар тухайн бүтээгдэхүүний тухай ерөнхий ойлголтыг авч гарч болох эрсдэлүүдийн тухай мэдлэгтэй болох юм. Даатгалын компаниудын мэргэжилтнүүдийн чадварыг нэмснээр даатгагч болон даатгалын бизнесийн салбарийн өсөлт нэмэгдэх юм.

Одоогийн хураамж тооцоолон аргачлал нь даатгалын компаний мэргэжилтний туршлага дээр үндэслэгдсэн байдаг, тиймээс уг удирдамж нь мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэхэд дөхөм болох юм.

ҮНДСЭН ЗАРЧМУУД

- Нөхөн төлбөрийн зарчим (**Indemnity**): даатгалын гэрээний дагуу даатгуулагчид тохиролцсон эрсдэл, аюулын улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх.
- Даатгалын сонирхолтой байх зарчим (**Insurable Interest**): Даатгуулагч өөрийн гэр байшиндаа л даатгалын сонирхолтой байхаас хөршийнхөө байшинд бус гэсэн зарчим юм. Даатгуулагч даатгалын хамаарах асуудлаар хууль эрх зүйн зөв харилцаатай байх. Энэ нь гэнэтийн ослын даатгалын хувьд хууль ёсны өв залгамжлал хүртэх эрх бүхий этгээдийг нэрлэж өгөх. Даатгуулагчийн гэр бүлийн гишүүдийг ирээдүйд бий болох санхүүгийн эрсдлээс хамгаалах үүднээс даатгуулах.
- Шууд шалтгааны зарчим (**Proximate cause**): Даатгуулагчийн даатгалын зүйлд эрсдэл учирсан анхдагч шалтгааныг илрүүлэх. Тухайн эрсдэл нь шууд буюу анхдагч эрсдэл байх ёстой.
- Туйлын үнэнч шударга байх зарчим (**Utmost good faith**): Даатгалын гэрээ байгуулагч талууд нь туйлын үнэнч шударга байх тухай бөгөөд гэрээнд оролцогч талуудын аль алинд ноогддог үүрэг юм. Даатгуулагч нь даатгалын гэрээ байгуулах эсвэл хүсэлт гаргах өргөдөл бөглөхдөө даатгуулах зүйлийнхээ талаар бүрэн гүйцэд үнэн зөв мэдээлэл өгөх үүрэгтэй. Эдгээр мэдээлэл дээр үндэслэн даатгагч эрсдлийг хүлээн авах эсэх, ямар хэмжээний хамгаалалт үзүүлэх эсэхээ шийддэг. Даатгагчийн хувьд даатгуулагчдад үйл ажиллагааны болон санхүүгийн хувьд ил тод нээлттэй, тунгалаг байх үүрэгтэй.
- Контрибуци зарчим (**Contribution**): энэ зарчим даатгалын компаниудын хооронд гарч ирдэг зарчим юм. Даатгуулагч өөрийн эд хөрөнгөө хэд хэдэн даатгуулагчид зэрэг даатгуулах, нөхөн төлбөрийг тэдгээр даатгагчаас авах хандлагатай байдаг учраас даатгалын компаниуд хоорондоо мэдээлэл, тооцооны харилцаатай байх гэсэн зарчим юм.
- Суброгаци зарчим (**Subrogation**): Даатгуулагчийн эд хөрөнгө амь насанд эрсдэл учирч түүнд нь гуравдагч этгээд буруутай бол даатгуулагчийн хохирлыг түргэн шуурхай барагдуулах ба гаргасан нөхөн төлбөр ба түүнтэй холбогдон гарах зардлын нийлбэрээр буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх зарчим юм.
- Маргаан шийдвэрлэх зарчим (**Arbitration**): Даатгал нь мөнгөтэй холбоотой харилцаа учраас маргаан үл ойлголцол гарах нь элбэг. Даатгуулагч, даатгагчийн хооронд маргааныг шийдвэрлэх нэг арга нь маргааныг шүүхээр бус

дундын гуравдагч этгээдийн шийдвэрийг хүлээн авч шийдвэрлэгэдэг хуулийн арга техник юм.

2. ДААТГАЛЫН БАТАЛГАА

ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү бүлэгт хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- **“гэнэтийн осол”** - гэрээний хугацаанд өвчний бус шалтгаанаар хөдөлмөрийн чадвараа алдахад хүргэсэн, даатгуулагчийн хүсэл эрмэлзлэлээс гадуур гэнэт богино хугацаанд бий болсон, урьдчилан харах боломжгүй, гаднын хүчин зүйлийн тааламжгүй нөлөөллийг;
- **“хөдөлмөрийн чадвараа бүрэн алдах”** - гэнэтийн ослын улмаас даатгуулагчийн бие эрхтний үүрэг нэлээд хэмжээгээр хязгаарлагдаж, эрүүл мэндэд учирсан хохирлын хэмжээ нь энэхүү бүлгийн 7.2-т заасны дагуу 80 ба түүнээс дээш хувиар тогтоогдохыг;
- **“хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдах”** - гэнэтийн ослын улмаас бие эрхтний бүрэн бүтэн байдал алдагдаж, эрүүл мэндэд учирсан хохирлын хэмжээ нь энэхүү бүлгийн 7.2-т заасны дагуу 80 хүртэл хувиар тогтоогдохыг;
- **“хөдөлмөрийн чадвар түр алдах”** - гэнэтийн ослын улмаас бие эрхтэнд гэмтэл бэртэл учирч даатгуулагч 90 хоног хүртэл хугацаанд ямар нэг хөдөлмөр эрхлэх боломжгүй болсныг.

ДААТГАЛЫН ХАМГААЛАЛТЫН ХЭМЖЭЭ

Жилийн дундаж цалингийн орлогын 3 жилийн үнэлгээнээс ихгүй байна.

ӨӨРИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

Дараах тохиолдуудад нөхөн төлбөрийн 10 хувьтай тэнцэх хэмжээг даатгуулагч хариуцна.

- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын шаардлагуудыг биелүүлээгүй.
- Хайхрамжгүй хандсан.
- Зайлсхийж, урьдчилсан сэргийлэх боломжтой эрсдэл тохиолдоход өөрийг хамгаалах арга хэмжээ аваагүй.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛҮҮД

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “Даатгалын Компани” ХХК-д (цаашид “Даатгагч” гэх) Монгол улсын иргэд болон тус улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугч гадаадын харъяат ба иргэний харъяалалгүй хүмүүс (цаашид “Даатгуулагч” гэх)-ийн амь нас, эрүүл мэндийг болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор даатгахтай холбоотой харилцааг зохицуулахад энэ нөхцөлийн зорилго оршино.
- 1.2. Монгол Улсын хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд энэхүү нөхцөлөөс өөрөөр заасан бол хууль, олон улсын гэрээг мөрдлөг болгоно.

ХОЁР. ДААТГАЛЫН ЗҮЙЛ

2.1. Монгол улсын иргэд болон тус улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суугч гадаадын харъяат ба иргэний харъяалалгүй хүмүүсийн амь нас, эрүүл мэнд;

ГУРАВ. ДААТГАЛЫН ЭРСДЭЛ

3.1. Даатгуулагчийг учирч болзошгүй дараах бүлэг эрсдлүүдээс даатгана. Үүнд:

- 3.1.1. Байгалийн бүх төрлийн эрсдэл (хүчит салхи, цасан ба шороон шуурга, үер, газар хөдлөлт, хөрсний нуралт, цөмрөлт, хүйтэн бороо, аянга, түймэр, усанд живэх, шавар намагт шигдэх, наранд цохиулах, элдэв хорт ургамалд хордох...);
- 3.1.2. Ахуйн эрсдэл (элдэв зүйлд цохиулах, хавчуулах, унаж бэртэх, альтрах, түлэгдэх, элдэв хорт хий, хоол, эмийн зүйлээс хордох, зам тээврийн аюул осолд өртөх, санамсаргүйгээр алдагдсан бууны суманд оногдох);
- 3.1.3. Үйлдвэрлэл-техникийн холбогдолтой эрсдэлүүд (машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгслэлтэй харьцах үед болон цахилгааны хүчдэл, дэлбэрэлт, шаталт, сантехник, дулааны шугам сүлжээний гэмтэл зэргийн нөлөөллөөр учирсан осол, химийн бодист хордох, хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөнөөс гарч болох осол);
- 3.1.4. Мал амьтдын нөлөөллөөр үүсэх эрсдлүүд (морь малаас унах, чирэгдэх, малд өшиглүүлэх, тийрүүлэх, хазуулах, араатан амьтан ба нохойд бариулах);
- 3.1.5. Бусдад хорлогдох, зодуулах, бууны сум болон хутга мэс зэрэг хүйтэн зэвсэгтэй дайралтанд өртөх;
- 3.1.6. Хүүхэд тоглож байх үедээ болон сургуулийн биеийн тамирын заал, талбай, цэцэрлэг, сургуулийн анги танхимд байх үед мөн гудамж, зам талбайд гарч болох ослоуд;
- 3.1.7. Уурхай нурах, дэлбэрэх, уурхай доторхи хорт хийнд хордох, угаартах, уурхайн цөмрөлт, гулсалт зэрэг эрсдэлүүд;
- 3.1.8. Жүжигчин, тамирчдын бэлтгэл дасгал сургуулилт хийх болон уралдаан тэмцээн, тоглолтын үед бэртэж гэмтэх зэрэг эрсдэлүүд;
- 3.1.9. Цагдаагийн болон авран хамгаалах тусгай албаны ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэх явах үеийн эрсдэлүүд;
- 3.1.10. Мэргэжлийн онцлогоос шалтгаалан гарах эрсдэлүүд;

ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Даатгуулагч нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

- 4.1.1. Даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгалын нөхөн төлбөрийг гэрээний дагуу даатгагчаас гаргуулахаар шаардах;
- 4.1.2. Даатгагч нь хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу даатгалын үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл аваагүй нь тогтоогдвол гэрээг цуцлах болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардах;
- 4.1.3. Даатгалын баталгааг даатгагчаар бичүүлж авах;
- 4.1.4. Даатгалын тохиолдол бий болсон үед нэн даруй даатгагчид мэдэгдэх, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ийнхүү мэдэгдэх боломжгүй байсан бол түүнийг гэрчилсэн нотолгоо, баримт, материалуудыг авчрах;
- 4.1.5. Даатгалын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;
- 4.1.6. Даатгал хийлгэхтэй холбогдсон баримт материалыг даатгагчид үнэн, зөв гаргаж өгөх;

- 4.1.7. Даатгагчид даатгалын эрсдэлийн хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг өгөх;
 - 4.1.8. Гэрээ байгуулагдсанаас хойш даатгуулагчдын нэрс болон ажил хөдөлмөрийн чиглэл өөрчлөгдсөн зэрэг гэрээтэй холбоотой аливаа өөрчлөлтийн талаар даатгагчид нэн даруй мэдэгдэх;
 - 4.1.9. Даатгалын хураамжийг хууль болон гэрээгээр тогтоосон хугацаанд төлөх;
 - 4.1.10. Даатгуулагч нь хэд хэдэн даатгагчид зэрэг даатгуулсан бол энэ тухай даатгагч бүрт мэдэгдэх;
 - 4.1.11. Даатгуулагч гэрээг цуцлах тухай санал гаргах;
 - 4.1.12. Даатгуулагч нь даатгалын баталгааг үрэгдүүлбэл даатгагчид мэдэгдэн зохих журмын дагуу хуулбар хувь бичүүлж авах;
- 4.2. Даатгагч нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- 4.2.1. Даатгуулагчийн гаргаж өгсөн мэдээ, материалын үнэн, зөв эсэхийг шалгах, шаардлагатай бол мэдээллийн талаар эрх бүхий байгууллага, хуулийн этгээдээс тодруулга авах;
 - 4.2.2. Хуурамч мэдээ, мэдээлэл өгсөн нь нотлогдох, түүнчлэн даатгалын хураамжийг хууль буюу гэрээгээр тогтоосон хугацаанд төлөөгүй бол гэрээг цуцлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардах;
 - 4.2.3. Даатгалын тохиолдол болсон үед шаардлагатай баримт бичгийг даатгуулагчаас шаардах;
 - 4.2.4. Монгол улсын даатгалын тухай хуулийн 8.5-р зүйлд заасан үндэслэл үүссэн тохиолдолд нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах;
 - 4.2.5. Даатгуулагч даатгалын хураамжаа төлсний дараа даатгагч даатгалын баталгааг бичиж олгох;
 - 4.2.6. 4.1.10-д заасан тохиолдолд бусад даатгагчтай хамтран нөхөн төлбөрийг олгох;
 - 4.2.7. Даатгуулагчид даатгалтай холбогдолтой хууль тогтоомж, бусад баримт материалыг танилцуулах;
 - 4.2.8. Хуульд зааснаас бусад тохиолдолд даатгуулагчийн талаарх мэдээллийн нууцыг хадгалах;
 - 4.2.9. Даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;

ТАВ. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

- 5.1. Даатгалын тохиолдолд болсон үед даатгагч гэрээнд заасны дагуу даатгуулагчид буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид эсвэл хууль ёсны өв залгамжлагчид нөхөн төлбөрийг олгоно;
- 5.2. Даатгуулагч даатгалын гэрээнд заасан эрсдлийн улмаас амь үрэгдэх болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан бол нөхөн төлбөрийг гэрээ болон даатгалын баталгаанд заасан үнэлгээг 100 хувиар олгоно;
- 5.3. Даатгуулагч нь даатгалын тохиолдол болсон үед энэ тухайгаа даатгагчид 72 цагийн дотор мэдэгдэнэ. Энэ хугацаанд мэдэгдээгүй тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг бууруулах үндэслэл болно;
- 5.4. Даатгуулагч нь даатгалын гэрээнд заасан эрсдэлийн улмаас гэнэтийн осолд орж тодорхой хугацаанд хөдөлмөрийн чадвараа алдсан бол түүний эмнэлэгт хэвтсэн, амбулатори болон гэрээр эмчлүүлсэн эмнэлгийн хуудсыг үндэслэн ажлын хоногоор

тооцсон хугацаанаас хамааруулан дор дурьдсан хувиар даатгалын үнэлгээнээс бодож нөхөн төлбөрийг олгоно. Үүнд:

- 5.4.1. 1-15 хоног эмчлүүлбэл – 10%
 - 5.4.2. 16-30 хоног эмчлүүлбэл – 15%
 - 5.4.3. 31-45 хоног эмчлүүлбэл – 20%
 - 5.4.4. 46-60 хоног эмчлүүлбэл – 30%
 - 5.4.5. 61-75 хоног эмчлүүлбэл – 40%
 - 5.4.6. 76-90 хоног эмчлүүлбэл – 50%
- 5.5. Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан бол – 100%
- 5.6. Даатгуулагч нь хөдөлмөрийн чадвараа хагас буюу алдалтыг эмч нарын зөвлөгөөнөөр:
-10-50% алдсан бол – 60%
-51-70% алдсан бол - 80%
- 5.7. Даатгагч нь даатгуулагчаас шаардлагатай бичиг баримтыг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор нөхөн төлбөрийг олгоно. Хохирлыг нөхөн төлөхөөс татгалзсан шийдвэр гаргавал үндэслэлийг тодорхой гаргаж даатгуулагчид мэдэгдэнэ;
- 5.8. Даатгалын нөхөн төлбөрийг нэхэмжлэх хөөн хэлэлцэх хугацаа нь Иргэний хуульд заасны дагуу 3 жил байна;
- 5.9. Нөхөн төлбөрийг авах эрх бүхий этгээд дараахь баримт бичгүүдийг бүрдүүлэн даатгагчид ирүүлнэ. Үүнд:
- 5.9.1. Даатгуулагчийн өргөдөл буюу албан бичиг;
 - 5.9.2. Даатгалын гэрээ, баталгааны эх хувь;
 - 5.9.3. Эмнэлгийн байгууллагын магадлагаа, тодорхойлолт;
 - 5.9.4. Даатгуулагчийн иргэний бичиг баримт хэрэв нас барсан бол хууль ёсны өв залгамжлагч мөн болохыг баталсан зохих байгууллагын тодорхойлолт;
 - 5.9.5. Нас баралтын гэрчилгээ буюу түүний албан ёсны хуулбар;
 - 5.9.6. 1.000.000-аас дээш үнэлгээгээр даатгуулсан тохиолдолд даатгалын тохиолдлын фото зураг
 - 5.9.7. Даатгуулагч буюу түүний ашиг сонирхлыг хамгаалагчийн зүгээс даатгалын тохиолдол үүсгэн хохирол учруулах зорилготой санаатай үйлдэл хийснээс үүссэн аливаа хохиролд даатгагч нөхөн төлбөр олгохоос татгалзана;
 - 5.9.8. Даатгалын нөхөн төлбөр олгогдсоны дараа даатгалын тохиолдолд буруутай гуравдагч этгээдээс төлбөр нэхэмжлэх эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ;
 - 5.9.9. Даатгуулагч нь даатгалын тохиолдлын улмаас тахир дутуу болсон бол дараах байдлаар нөхөн төлбөр олгоно. Үүнд:

5.9.9.1. Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдах	100%
5.9.9.2. Хоёр нүд хараагүй болох	100%
5.9.9.3. Хоёр мөч үгүй болох	100%
5.9.9.4. Нэг нүд хараагүй болох	50%
5.9.9.5. Нэг мөч үгүй болох	50%
5.9.9.6. Ярих чадвараа алдах	50%
5.9.9.7. Хоёр чих сонсголгүй болох	50%
5.9.9.8. Нэг чих сонсголгүй болох	20%
5.9.9.9. Эрхий хуруугүй болох /хоёр үе/	20%
5.9.9.10. Эрхий хуруугүй болох / нэг үе/	10%
5.9.9.11. Ямар нэг хуруугүй болох /нэгээс илүү үе/	10%
5.9.9.12. Ямар нэг хуруугүй болох/ нэг үе/	5%
5.9.9.13. Хөлийн эрхий хуруугүй болох	5%

5.9.9.14. Хөлийн ямар нэг хуруугүй болох 2%

- 5.10. Даатгуулагч нь гэнэтийн ослын улсаас тодорхой хугацаанд хөдөлмөрийн чадвараа алдан, тахир дутуу болсон тохиолдолд 5.4 ба 5.10-р зүйлд заасны дагуу нөхөн төлбөрийг тооцон давхардуулахгүйгээр аль ихийг нь олгоно ;
- 5.11. Даатгуулагч өмнө нь гэнэтийн осолд орж зохих хэмжээний даатгалын нөхөн төлбөр авсан боловч даатгалын хугацаа дуусаагүй бол даатгалын гэрээ хүчин төгөлдөр хэвээр үргэлжилнэ. Харин даатгуулагчийн хэсэгчлэн авсан нөхөн төлбөрийн нийт хэмжээ нь гэрээт баталгаанд заасан даатгалын үнэлгээний хэмжээтэй тэнцүү байвал даатгалын гэрээний хугацааг дууссанд тооцно. Хэсэгчлэн авсан нөхөн төлбөрийн хэмжээгээр даатгалын үнэлгээ буурна;

ЗУРГАА. ДААТГАЛЫН ГЭРЭЭГ ДУУСГАВАР БОЛГОХ, ЦУЦЛАХ

- 6.1. Гэрээг дуусгавар болгох үндэслэлүүд. Үүнд:
- 6.1.1. Гэрээний хугацаа дууссан;
 - 6.1.2. Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн;
 - 6.1.3. Талууд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахаар тохиролцсон;
 - 6.1.4. Шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;
- 6.2. Даатгагчийн буруугаас гэрээг хугацаанаас өмнө цуцлахад хүрвэл даатгуулагчийн төлсөн хураамжийг бүрэн хэмжээгээр, даатгуулагчийн буруугаар гэрээг цуцалбал үлдсэн хугацаанд ногдох хураамжаас тухайн даатгалтай холбогдсон зардлыг хасаж, үлдэх хэсгийг даатгуулагчид эргүүлэн олгоно;

ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

- 7.1. Гэрээний биелэлт болон гэрээтэй холбоотой бусад асуудлаар гарсан аливаа маргааныг талууд юуны түрүүнд эв зүйгээр шийдэхийг эрмэлзэнэ. Хэрэв ийнхүү шийдэж, тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд хуульд заасан журмаар Монгол Улсын шүүхэд тавьж шийдвэрлүүлнэ.
- 7.1.1. Нас баралт
 - 7.1.2. Хөдөлмөрийн чадвар бүрэн алдалт
 - 7.1.3. Хөдөлмөрийн чадвар хэсэгчилсэн алдалт
 - 7.1.4. Хөдөлмөрийн чадвар түр алдалт

БУСАД ТУСГАЙ ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН

АЯЛАЛЫН ДААТГАЛ

ХАМРАХ ХҮРЭЭ

Даатгуулагч өөрийн байнгын оршин суух улсаас өөр гадаад оронд буюу даатгалын нөхцөлд заасан бүс нутагт, даатгалын хугацаанд аялаж байх явцад өөрөөс нь хамааралгүйгээр учирсан гадны нөлөөллийн улмаас эрсдэлд орсон тохиолдолд даатгалын компани нь тусламж туслалцаа үзүүлнэ. Энэхүү гэрээний хамгаалалт нь даатгуулагчийн даатгалын хугацаа дуусах буюу даатгуулагч нь өөрийн байнгын оршин

суух улсад эргэн ирхэд дуусгавар болох болно. Энэхүү даатгал нь нэг аялалын хугацаа нь тасралтгүй 90 хүртэлх хоногийн хугацаанд хүчинтэй байна.

А ХЭСЭГ: ИРГЭДЭД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

1) Гадаад дахь эмнэлэг, эмчилгээний зардал.

Гадаад улсад буюу өөрийн байнгын оршин суух улсаас өөр улсад аялж байх хугацаанд өвчлөх, гэнэтийн осолд орсоны улмаас, эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх, эмчилгээ болон мэс засал хийлгэх, эмчийн зааврын дагуу хэрэглэх эм тарианы зайлшгүй хэрэгцээтэй зардлууд төлөгдөнө. Компанийн эмнэлгийн баг нь даатуулагчийг эмчилж байгаа эмнэлэг болон хариуцсан эмч нартай байнгын утсан холбоогоор харилцаж даатуулагчийн биеийн байдлыг байнга хянаж байна.

Даатгалын хамгааллын дээд хэмжээ нь 50.000 ам.доллар байна.

Даатгалын хасалт нь даатгалын тохиолдолд тутамд 50 ам.доллар байна.

2) Гэнэтийн осол болон өвчний улмаас тээвэрлэлт болон эх орон руу буцаах зардал.

Даатуулагч гадаад оронд аялаж байх хугацаандаа өвчлөх болон гэнэтийн осолд орсон тохиолдолд түүний эмчилгээний байгууллагад хүргэх болон эх орон руу нь яаралтай буцаах зардлыг даатгагч хариуцна.

Даатгагч нь өөрийн эмнэлгийн багийн дүгнэлтэд үндэслэн даатуулагчийг хэвтэж эмчлүүлэх эмнэлгийг сонгон, эсвэл эх орон руу нь буцаах шаардлагатай эсэхийг шийднэ.

Даатгагчийн эмнэлгийн баг нь шаардлагатай гэж үзвэл даатуулагчийн биеийн байдлыг харгалзан үзэж түүнийг аль тохиромжтой тээврийн хэрэгслээр эх оронд нь буцаана.

Даатуулагчид хөнгөн өвчлөлт болон бага зэргийн гэмтэл учирсан бол түргэн тусламжийн тээвэрлэлт болон бусад боломжтой тээврийн хэрэгслээр эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад хүргэнэ.

3) Шүдний эмчилгээний зардал.

Даатгагч нь даатуулагчийн гадаадад аялах хугацаанд учрах яаралтай шүдний эмчилгээний зардлыг нөхөн төлнө.

Даатгалын хамгаалалтын дээд хэмжээ нь 450 ам.доллар

Даатгалын хасалт нь даатгалын тохиолдолд тутамд 50 ам.доллар байна.

Энэхүү хамгаалалт нь шүдний өвчлөлт, халдвар авалтанд хийх эмчилгээ, шүд авахуулах зэрэг эмчилгээгээр хязгаарлагдана.

4) Даатуулагчийн гэр бүлийн гишүүнийг яаралтай эх оронд нь буцаах зардал.

Даатуулагч нь гадаад оронд аялаж байх хугацаандаа өвчлөх, гэнэтийн осолд орсоноос, эмнэлэгт 10 буюу түүнээс дээш хоногоор эмчлүүлэх, эсвэл нас барсан тохиолдолд, түүнийг дагалдаж яваа гэр бүлийн гишүүнийг нь эх оронд нь буцаах зардлыг даатгагч хариуцна.

5) Шарилыг эх орон руу нь буцаах зардал.

Даатуулагч гадаад оронд аялаж байх хугацаанд өвчлөх болон гэнэтийн осолд орж, нас барсан тохиолдолд шарилыг тээвэрлэж, эх оронд нь буцаах, эх оронд нь оршуулах болон чандарлах газар хүртэлх тээвэрлэлтийн зардлыг даатгагч хариуцна.

Дээрх зардалд чандарлах болон оршуулах зардал хамаарахгүй.

6) Гэр бүлийн нэг гишүүний замын зардал

Даатгуулагч гадаад оронд аялаж байх хугацаанд өвчлөх, гэнэтийн осолд орж эмнэлэгт 10 буюу түүнээс дээш хоногоор хэвтэж эмчлүүлэх тохиолдолд, даатгуулагчийн гэр бүлийн нэг гишүүнийг байнга оршин суух орноос нь даатгуулагчийн хэвтэж эмчлүүлж байгаа улс, хот руу ирж очих тээвэрлэлтийн зардал болон тухайн орон нутагт байх зардал буюу өдрийн 85 ам.доллараар тооцон дээд тал нь 10 хоногийн зардлыг даатгагч хариуцна.

7) Гэр бүлийн гишүүн нь нас барсан тохиолдолд яаралтай эх орондоо буцах замын зардал.

Даатгуулагчийг гадаад оронд аялаж байх хугацаанд эх оронд нь байгаа гэр бүлийн гишүүн нь нас барсан тохиолдолд, даатгуулагчийн эх орондоо буцах замын зардлыг даатгагч хариуцна. Даатгагч нь даатгуулагчийн аялалаа яаралтай зогсоох шаардлагатай болсон бичиг баримт болон, гэр бүлийн гишүүний нас барсаны гэрчилгээ болон бусад нотлох баримтуудыг даатгагчид ирүүлнэ.

8) Эм тариа хүргэх зардал

Даатгуулагчийн биеийн байдлаас шалтгаалж эмчийн зааврын дагуу бичигдсэн болон аялалаас өмнөх эмчийн заавраар бичигдсэн эм тариа нь тухайн орон болон бүс нутагт байхгүй тохиолдолд эм тариаг тухайн эмчлүүлж байгаа улс орон нутагт хүргэх зардлыг даатгагч хариуцна.

9) Яаралтай мэдээ хүргэх зардал

Даатгалын тохиолдол болсон үед энэ тухай даатгуулагчийн гэр бүлийнхэнд яаралтай мэдэгдэх, үйлчилгээг даатгагч бүрэн хариуцна.

10) Батлан даалтын зардал.

Даатгуулагчийн хуулийн дагуу хариуцлага хүлээхэд дээд тал нь 850 ам.долларын батлан даалтыг даатгагч хариуцна. Даатгуулагч нь батлан даалтад гаргасан зардлыг компанид 45 хоногийн дотор буцаан нөхөн төлнө.

11) Мөнгөн хохирол барагдуулах зардал.

Даатгуулагч гадаад оронд аялаж байх хугацаанд хулгай дээрэмд өртөх, ачаа тээшээ алдах, өвчин болон гэнэтийн ослын улмаас бэлэн мөнгөгүй болсон болон биеийн байцаалтыг батлах бичиг баримтгүйн улмаас шилжүүлэг болон банкнаас бэлэн мөнгө авч чадахгүй болсон тохиолдолд дээд тал нь 850 ам.долларын нөхөн төлбөрийг даатгагч хариуцна.

12) Гадаад паспорт жолооны болон иргэний үнэмлэхээ алдсан тохиолдолд эргүүлэн сэргээх зардал.

Даатгуулагч гадаад оронд аялаж байх хугацаандаа гадаад паспорт, жолооны болон иргэний үнэмлэхээ алдсан тохиолдолд тэдгээрийг буцаан сэргээх зардал болон тэдгээр бичиг баримттай тэнцэх эрх зүйн чадамжтай бичиг баримт гаргахад дээд тал нь 250 ам.долларын зардлыг даатгагч хариуцна.

13) Хууль шүүхийн байгуулгын өмнө хүлээх хариуцлагын зардал.

Даатгуулагч гадаад оронд аялаж байх хугацаанд зам тээврийн ослоос болж хуулийн болон хувь хүний өмнө хариуцлага хүлээх тохиолдолд өөрийгөө хамгаалах буюу өмгөөлөгч, хуулийн зөвлөх, хуулийн товчооны үйлчилгээний зардалд зориулан дээд тал нь 2100 ам.долларын төлбөрийг даатгагч хариуцна.

Б ХЭСЭГ: АЧАА ТЭЭШ АЛДАГДАХ БОЛОН НИСЛЭГ ХОЙШЛОГДОХ ҮЕД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Даатгуулагчийн өөрийн ачаа тээш болон хувийн эд зүйлс нь доорх даатгалын нөхцөлд хамрагдана.

Бүх даатгалын тохиолдолд тухайн ачаа тээшийг тээвэрлэлтийн үед алдсан гэх бүх бичиг баримтыг бүрдүүлнэ.

1) Нислэгийн үед ачаа тээш алдагдах зардал.

Даатгуулагч нь гадаад оронд аялаж байх хугацаанд тээвэрлэгчийн хариуцлагагүй, буруутай үйл ажиллагаанаас болж ачаа болон гар тээшээ алдах тохиолдолд түүнийг буцаан олж авах зардалд дээд тал нь 210 ам.доллар төлөгдөх бөгөөд, даатгуулагч нь тухайн алдагдсан ачаа тээш, гар тээшинд ямар ямар эд зүйл байсан болон дундаж ойролцоох үнэ, худалдаж авсан огноо гэх мэдээллийг даатгагчид гаргаж өгөх үүрэгтэй.Алдагдсан ачаа тээшний нөхөн төлбөрийг олгохдоо “Олон улсын агаарын тээврийн байгуулгууллагын ачаа тээврийн өмнө хүлээх хариуцлага”-ын журмыг мөрдлөг болгоно.

Ачаа тээш алдагдсанаас хойш 21 хоногийн дараа ачаа болон гар тээшийг бүрмөсөн алдагдсан гэж үзэж нөхөн төлбөрийг олгоно.

Бэлэн мөнгө, үнэт эдлэл /бүх төрлийн бөгж, ээмэг, хүзүүний зүүлт г.м /, бүх төрлийн карт болон бичиг баримтыг алдсан тохиолдолд нөхөн төлбөр олгогдохгүй.

2) Ачаа тээш нислэгээс хоцорж ирэх

Даатгагч нь I.A.T.A буюу Олон улсын Агаарын Тээврийн Холбоонд бүртгэлтэй агаарын тээврийн компаниар тээвэрлэгдсэн буюу бүртгэлтэй ачаа доод тал нь 6 цаг хоцорсон тохиолдолд зайлшгүй шаардлагатай хэрэгцээний зүйл авахад нь зориулж дээд тал нь 100 ам.долларын нөхөн төлбөрийг даатгуулагчид олгоно.

Ачаа тээш хоцорсон тухай агаарын тээврийн компаниас гаргасан баримт бичгийг зайлшгүй бүрдүүлж даатгагчид өгнө.

3) Ачаа тээшийг хойноос нь хүргүүлэх зардал

Даатгагч нь даатгуулагчийн хулгай, дээрмийн үүдэлтэйгээр алдагдсан ачаа, гар тээш болон хувийн эд зүйлсийг олж барагдуулахтай холбоотой зөвлөгөөг өгч, хэрэв олдсон тохиолдолд даатгуулагчийн аялалын дараагийн төлөвлөгөөнд орсон улс орон эсвэл байнгын орших суух улс руу нь хүргүүлэх зардлыг хариуцна.

В ХЭСЭГ НИСЛЭГ ХОЙШИЛСОН ИЙ ЗАРДАЛ

Даатгуулагч гадаад оронд аялаж байх хугацаанд төлөвлөгдсөн маршрутын дагуух нислэг хамгийн багадаа 6 цагаар хойшлогдсон тохиолдолд даатгагч нь хойшлогдсон тухай баримт бичиг болон бусад зардлын баримтыг үндэслэн хойшлогдсон хугацаанд хамаарагдах нэмэгдэл зардлыг хариуцна. Нэмэгдэл зардал (Тээвэр, зочид буудал болон хоол ундны зардал) нь доор дурьдсан хязгаарлалтын дагуу төлөгдөнө. Үүнд:

- Нислэг 6 цагаас илүү хойшлогдсон бол 45 ам.доллар хүртэл
- Нислэг 12 цагаас илүү хойшлогдсон бол нэмэлт 45 ам.доллар
- Нислэг 18 цагаас илүү хойшлогдсон бол нэмэлт 45 ам.доллар
- Нислэг 24 цагаас илүү хойшлогдсон бол нэмэлт 45 ам.доллар

Нөхөн төлбөр нь зардлын баримтын эх хувь дээр үндэслэгдэн дээд тал нь 180 ам.долларын хэмжээнд олгогдоно. Энэхүү хамгаалалтаар Агаарын тээврийн компанийн ажилчдын буруу үйл ажиллагаа, ажил хаялт болон тухайн агаарын тээврийн компанитай давхар гэрээтэй байсан үйлчилгээний байгууллага болон нисэх буудлын буруутай үйл ажиллагаанаас үүдэн нислэг хойшилсон тохиолдолд ямар нэг нөхөн төлбөр олгогдохгүй болно. Мөн хуваарьт нислэгт багтаагүй нислэг хойшлогдсон тохиолдол дээрх үйлчилгээнд хамаарагдахгүй.

В.ХЭСГИЙН НӨХЦӨЛ БОЛОН ХЯЗГААРЛАЛТ

- 1) Даатгуулагч нь тухайн хойшилсон нислэгийнхээ талаарх тодорхойлолт болон шалтгаан зэргийг тусгасан баримт материалыг агаарын тээврийн компаниас шаардаж авна.
- 2) Нөхөн төлбөрийг тооцохдоо аялалын төлөвлөгөөний дагуу нисэх байсан хоног цагаас эхлэн хойшлосон хугацааг тооцно.

ХАРИУЦЛАГЫН НӨХЦӨЛ

- 1) Даатгалын тохиолдол болоход даатгуулагч нь гэрээний үүргээ бүрэн хүлээгээгүй үед компани нь нөхөн төлбөрийг хязгаарлалттайгаар олгоно.
- 2) Даатгалын тохиолдол болоход даатгуулагч дараах үүрэг хүлээнэ:
 - а) Хохирлын хэмжээг багасгах, хохирлоос зайлсхийх бүхий л арга хэмжээг авах;
 - б) Хохирол болсон тохиолдолд даатгагчид нэн даруй мэдэгдэж, нөхөн төлбөрийн зөвлөгөө авах;
 - в) Даатгагчид бүх төрлийн шаардлагатай мэдээллийг өгөх;
 - д) Даатгагчийн зөвшөөрөлгүйгээр санал гаргах, санал тавих, төлбөр тооцоо хийж өөрөө хохирлыг барагдуулах оролдлого хийхгүй байх;
- 3) Даатгагч нь бусад даатгалын нөхцөл болон өөр даатгагчтай байгуулсан гэрээгээр хамгаалагдсан болон ижил нөхөн төлбөр гарах бол Даатгагч нөхөн төлбөр төлөх хариуцлага хүлээхгүй.

НӨХӨН ТӨЛБӨР

- 1) Даатгуулагч нь даатгалын тохиолдол болсон үед энэ тухайгаа даатгагчид нэн даруй мэдэгдэнэ.
- 2) Даатгуулагч нь нөхөн төлбөр авахын тулд дараах баримт материалыг бүрдүүлэн даатгагчид ирүүлнэ. Үүнд:
 - Даатгуулагчийн өргөдөл буюу албан бичиг;

- Даатгалын гэрээт баталгааны эх хувь;
- Эмнэлэгийн байгууллагын магадлагаа, тодорхойлолт, төлбөрийн баримтууд;
- Даатгуулагчийн иргэний бичиг баримт, хэрэв нас барсан бол хууль ёсны өв залгамжлагч мөн болохыг нотолсон зохих байгууллагын тодорхойлолт;
- Нас барсны гэрчилгээ буюу түүний албан ёсны хуулбар;
- Яаралтай эмнэлгийн үйлчилгээ авсан тухай төлбөр тооцооны баримтын эх хувь;
- Даатгуулагчийн аялалаа яаралтай зогсоох шаардлагатай болсон тухай бичиг баримт, гэр бүлийн
- гишүүний нас барсаны гэрчилгээ болон бусад нотлох баримтууд;
- Шарилыг эх оронд нь хүргэсэн тухай тээврийн байгууллагын баримт;
- Аялалын үед алдагдсан ачаа тээшийн холбогдолтой бичиг баримт;
- Даатгуулагчийн ачаа тээш хоцорсон тухай агаарын тээврийн компаниас гаргасан тодорхойлолт,
- баримт;
- Даатгуулагчийн нислэг хойшилсон тохиолдолд хойшилсон үед гарсан нэмэгдэл зардлын баримтын эх хувь.
- Бусад хэрэгцээтэй баримт бичгүүд

БҮХ АЯЛАЛД ХЭРЭГЖИХ НӨХЦӨЛ

Гэр бүлийн хүмүүс: Эхнэр, Нөхөр, Эцэг, эх, Хараа хяналтанд байх 18 нас хүрээгүй хүүхэд.

Даатгалаын хугацаа: Нэг аялалаар 90 хүртэл хоногоор гадаадад аялах.

Жилийн хамгаалалт: Нэг жилийн хугацаанд 90 хүртэл хоногоор гадаадад аялах.

Үнэ нь ам.доллар

Даатгагдах хүний насны дээд хязгаар: 80 нас

(71-ээс 79 настай иргэний төлөх, хураамжийн хэмжээ 2 дахин их)

(80-аас 84 настай иргэний төлөх, хураамжийг хэмжээ 3 дахин их)

А БҮС АЗИ 50,000 ам.доллар

Б БҮС Шенгений орнууд 50,000 ам.доллар

В БҮС Дэлхий даяар (АЗИ болон Шенгений бүсийн орнуудад) 50,000 ам.доллар

3. ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ЖУРАМ

ЦУЦЛАХ НӨХЦӨЛ

Гэрээг дуусгавар болгох үндэслэлүүд. Үүнд:

- Гэрээний хугацаа дууссан;
- Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн;
- Талууд гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахаар тохиролцсон;
- Шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;

Даатгагчийн буруугаас гэрээг хугацаанаас өмнө цуцлахад хүрвэл даатгуулагчийн төлсөн хураамжийг бүрэн хэмжээгээр, даатгуулагчийн буруугаар гэрээг цуцалбал үлдсэн хугацаанд ногдох хураамжаас тухайн даатгалтай холбогдсон зардлыг хасаж, үлдэх хэсгийг даатгуулагчид эргүүлэн олгоно;

АНХААРУУЛГА, МЭДҮҮЛЭГ

Гэрээ дуусгавар болсоныг даатгуулагчид 72 цагийн дотор мэдэгдэнэ.

4. ДААТГАЛЫН ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ НӨХЦЛҮҮД

Дараах нэмэлт нөхцлүүдийг оруулж болно. Үүнд:

- Даатгуулагч 16-50 настай байх
- Даатгуулагчийн эрүүл мэнд хэвийн байх
- Хэрэв бүлгээр даатгах бол хамгийн ихдээ 85 даатгуулагч даатгах
- Нийт даатгах үнэлгээ нь 1,000,000,000 төгрөг байх

Дараах хасалтуудыг нэмэлтээр оруулж болно. Үүнд:

- Сураггүй алга болох
- Дэлбэрэлтэнд ортох
- Мотоциклоор явж байгаад бэртэх
- Дайралт, үймээн самуунд өртөх
- Террорист халдлага, дэлбэрэлтэнд өртөх
- Амиа хорлох
- Даатгуулахаас өмнөх үеийн физик гэмтэл
- Өнгөний өвчин, паразитийн халдвар авах, ДОХ
- Хүүхэд төрүүлэх, жирэмслэлтийн явцын гэмтэл
- Хууль бус үйлдэл хийж байгаад гэмтэх
- Дайн, иргэний дайн, бослого, хувьсгалт мөргөлдөөний үеийн гэмтэл
- Машины, хурдан морины уралдаанд орох үеийн гэмтэл
- Аюултай спортоор хичээллэх үеийн гэмтэл, ууланд авирах, шүхрээр буух, олстой үсрэлт,
- Согтууруулах, мансууруулах бодис хэрэглэсэн үеийн гэмтэл
- Зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл барьж явсан үеийн гэмтэл

НӨХӨН ТӨЛБӨР АВАХ СХЕМ

Нас барах	100%
Хөдөлмөрийн чадвараа алдах	100%
Нэг болон хоёр нүдний хараагүй болох	100%
Ясны хугарлын үед:	
Хоёр гуя	100%
Мөр	100%
Тохойноос мөр хүртлэх	100%
Тохойны бэртэл	100%
Шуу	100%
Бугалга	100%
Гуя, шилбэ, шагайны бэртэл	100%
Нүдний бэртэл	
Өнгө болон дүрс ялгахгүй болох	50%
Нэг нүдний хараа муудах	50%
Бусад үений хугарал:	
Гарын 5 хуруу	50%
Дөрвөн хуруу	40%
Нэг эрхий хуруу	25%
Хоёр эрхий хуруу	10%
Гурван хуруу	10%
Хоёр хуруу	8%
Нэг хуруу	4%
Сонсгол алдагдах	
Хоёр чихний сонсгол	75%
Нэг чихний сонсгол	15%
Хэл, ярианы чадваргүй болох	50%

5. ЕРӨНХИЙ ХАСАЛТУУД

Энэхүү гэрээний хамгаалалтанд доор дурьдсан эрсдлүүд, тухайн эрсдлүүдээс үүссэн хохирол хамаарагдахгүй бөгөөд хасалт болж нөхөн төлбөр олгогдохгүй болно.

- а) Даатгуулагчийн санаатай үйлдэл, гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаанд оролцсон болон түүний үр дагавраас үүссэн, хууран мэхлэх үйлдэл, хэт хайхрамжгүй байдлаас үүссэн хохирол. Мөн сэтгэлзүйн тогтворгүй буюу солиорлын үед, сэтгэцийн эмчилгээний зардал нь хасагдал болно;
- б) Үер, газар хөдлөлт, хөрсний нуралт, галт уулын дэлбэрэлт, циклоний шуурга, агаарын биет болон сансараас унасан биет, цаг агаарын, байгалийн, геологийн ер

- бусын үзэгдэл буюу хүний хүчин зүйлээс үл хамаарах давагдашгүй хүчин зүйлээс үүдэлтэй хохирлууд;
- с) Үймээн самуун, бослого болон терроризмын үйл ажилгаанаас үүдэлтэй хохирол;
 - d) Энхийн цагт цэрэг арми, дотоодын цэргийн үйл ажилгаанаас үүдэлтэй хохирол;
 - е) Олон улсын зэвсэгт мөргөлдөөн болон зарласан болон зарлаагүй дайнаас үүдэлтэй хохирол;
 - f) Цөмийн болон радио итэвхит бодисын нөлөөллөөс үүсэн хохирол;
 - g) Даатгуулагч мөрийтэй болон бооцоотой тоглоомонд оролцох, зайлшгүй бие хамгаалахаас бусад үед хийсэн зодооноос үүссэн хохирол;
 - h) Даатгуулахаасаа өмнө өвчтэй, гэмтсэн байсан тохиолдол;
 - i) Олон улсын чанартай спорт тэмцээн уралдаан, бэлтгэл сургуулилт болон туршилтанд оролцоноос үүсэх хохирол;
 - j) Мото спорт болон мотоциклийн уралдаан, ангийн спортод оролцох, амьсгалын баг хэрэглэл ашиглан усанд шумбах, олон улсын далайн бүсэд хүн тээврийн бус усан хөлгөөр аялах, морь унах, уул хаданд авирах, агуйд аялах, бокс, бөх, бие хамгаалах бүх төрлийн спорт, шүхрээр буух, агаарын бөмбөрцөгөөр аялах, өндрөөс чөлөөт үсрэлт хийх, гулсах болон бүх л төрлийн хүний бие эрүүл мэндэд хор нөлөөтэй байж болохуйц бүх төрлийн спортод оролцоноос үүссэн хохирол;
 - к) Спортын холбооноос зохион байгуулсан бүх төрлийн спортын тэмцээн уралдаанд оролцох үед гарсан хохирол;
 - l) Цанаар гулгах болон түүнтэй адил спортод оролцож байх үед учирсан хохирол;
 - m) Гадаад оронд байнга оршин суугч болон гадаадад сурж буй Монголын иргэн;
 - n) Олон нийтэд үйлчилдэггүй хүн тээвэрлэх зөвшөөрөлгүй бүх төрлийн тээврийн хэрэгсэл болон нисдэг тэргээр зорчих;
 - o) Ажил хийж байх тохиолдолд ажлын байран дээрх осол гэмтэл мэргэжлээс шалтгаалах өвчлөл;

DOORX TOXHOJДOЛД НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХООС ТАТГАЛЗАНА.

- a) Нэн яаралтай тохиолдлоос бусад тохиолдолд даатгагчид мэдэгдэлгүйгээр , уг байгуулгын зөвшөөрөлгүйгээр даатгуулагчийн авсан үйлчилгээ. Хэрэв яаралтай үйлчилгээ авах шаардлага гарсан бол Даатгагчид бүрдүүлж өгөх бүх төрлийн баримт нэхэмжлэл, төлбөр тооцооны баримтыг эх хувиар нь бүрдүүлнэ.
- b) Даатгуулахаас өмнө өвдөж байсан архаг хууч өвчин, бэртэж байсан гэмтэл нь сэдэрсэн тохиолдол:
- c) Амиа хорлож нас барсан эсвэл амиа хорлох гэж оролдсоны үр дагавраас гарсан хохирол
- d) Архи, согтууруулах ундаа, хорт бодис, мансууруулах бодон сэтгэцэд нөлөөлөх бодис болон эмчийн эмийн жорд бичигдээгүй эмийг сайн дураар тун хэтрүүлж ууснаас үүдэх эрсдэл болон ямарваа нэгэн сэтгэл мэдрэлийн өөрчлөлт болон өвчлөлт:
- e) Даатгагчийн санал болгосон эмнэлэг эмчилгээний байгууллага руу шилжүүлэх, тээвэрлэх асуудлыг даатгуулагч болон түүнийг төлөөлж буй хүмүүс татгалзсан тохиолдол:
- f) Нөхөн сэргээх буюу архи, тамхи, мансууруулах болон бусад сэтгэцэд нөлөөлдөг бодисоос гаргах эмчилгээ:

- g) Протез, хиймэл эрхтэн, ортопед буюу хиймэл үе мөч, остесентиз буюу нэмэлт бэхэлгээний материал болон харааны шил:
- h) Жирэмсний үе дэх өвчлөлт, төрөлт, төрөлтийн үе дэх хүндрэл, үр хөндөлт:
- i) Хагарч гэмтэж болзошгүй эмзэг ачаа тээшийг зориулалтын бус сав баглаанд хийж зохих ёстой тэмдэг тэмдэглэгээг наагаагүйн улмаас ачаа тээш эвдэрж хэмхэрсэн тохиолдол:
- j) Доор дурьдагдсан тохиолдолд даатгалын үйлчилгээ болон нөхөн төлбөр олгогдохгүй:
 - Даатгалын хугацааны өмнө болон дараа учирсан хохирол:
 - Эмчилгээ хийлгэх, эмнэлгийн үйлчилгээ авах зорилготойгоор гадаад оронд зорчсон бол
 - Өвчний онош тавигдсаны дараа гадаад оронд зорчсон:
 - Эмнэлгийн зөвшөөрөлгүйгээр буюу эмчилгээгээ дуусаагүй байх үедээ гадаад оронд зорчсон.

6. ЭРСДЭЛИЙН БҮЛГҮҮД

МЭРГЭЖЛИЙН БҮЛЭГ

- Хэвийн эрсдэлтэй мэргэжил: Хуульч, Нягтлан, архетиктурч, банкны ажилтан, зөвлөх инженер, багш, офиссын ажилчин
- Дунд эрсдэлтэй мэргэжил: Барилга, констракторын инженер, ажилчид, малын эмч, жолооч, лабораторын ажилчин
- Өндөр эрсдэлтэй мэргэжил: Уул уурхайн ажилчид, дэлбэрэлт, цахилгаан, өндөр хүчдэлийн инженер мэргэжилтэн, циркийн жүжигчид, уралдааны машины жолооч, хурдан морь унаач, анчин, уулчин, өвлийн спортын тамирчин,

ХУВЬ ХҮНИЙ СОНИРХОЛЫН БҮЛЭГ

- Экстрим спорт сонирхогч: Мотоспорт, шүхрээр үсрэх, зодооны урлагаар хичээллэх, бүх төрлийн уралдаан (машины, хурдан морины)
- Ан хийх
- Ууланд авирах
- Загасчлах гэх мэт

7. ХУРААМЖ ТООЦОХ ПАРАМЕТРУҮД

Эрсдэлийн хүчин зүйлийг тооцолохдоо тухайн ажил мэргэжлийн нөхцөлөөс гадна хувь хүний амьдардаг орчин (гэр хороололд амьдардаг бол галын болон угаарын эрсдэл, зам тээврийн эрсдэл болон хальтирах унах гадны халдлага нөлөөлөх магадлал ихсэх хандлагатай), сонирхдог зүйлийн эрсдэл спортын төрөл болон хобби ан агнах хөдөө гадаа явах загасчлах морь сургах байгальд аялах гэх мэт сонирхдог зүйлийн эрсдэлийг тооцох, мөн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйл сонсгол харааны өөрчлөлт тулгуур эрхтэний өөрчлөлт, мэдрэл сэтгэцийн өөрчлөлт зэрэг эрсдэлийг тооцоно. Мөн биеийн жингийн индекс нөлөөлдөг. Энэ нь амьдралын эрүүл хэв маягын үзүүлэлт болдог.

Risk prevention and safety measures (corporate): Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журам мөрдөнө. Журмыг хэрэгжүүлж, мэргэжлийн хариуцсан ажилтантай байна.

Удирдлагын мэдээллийн системд доорх үндсэн мэдээллүүдийг үүсгэнэ:

- Нас
- Хүйс
- Шашин
- Цалин
- Мэргэжил
- Газар зүйн байршил
- Нийт үнэлгээ
- Даатгуулсан гэрээ
- Нөхөн төлбөрийн тоо

8. ХУРААМЖ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Актуарын нөхцөлүүд

Нэхэмжлэлийн давтамж:	Давтамж = $\frac{\text{Нэхэмжлэлийн тоо}}{\text{Даатгуулагчдын тоо}}$
Нэхэмжлэлийн Дундаж дүн:	Дундаж дүн = $\frac{\text{Нэхэмжлэлийн нийт дүн}}{\text{Нэхэмжлэлийн тоо}}$
Цэвэр хураамж	Цэвэр хураамж = $\frac{\text{Нэхэмжлэлийн нийт дүн}}{\text{Даатгуулагчдын тоо}}$

Үндсэн үнэлгээний нөхцлүүд

- Хамралт – Бичигдсэн / Тооцсон / Тооцоогүй / Төлөх ёстой
- Хураамж – Бичигдсэн / Тооцсон / Тооцоогүй / Төлөх ёстой
- Нэхэмжлэл – Төлөгдсөн / Учирсан / IBNR / IBNER
- Хохирол засварлалтын зардлууд – Хуулийн төлбөр, Шалгагчийн төлбөр, Нэхэмжлэл шийдвэрлэх зардал г.м
- Андеррайтингийн зардлууд нь үйл ажиллагааны болон удирдлагын зардлуудыг агуулна: Цалин, Татвар, Төлбөр г.м
- Маркетингийн зардлууд – Шимтгэл & Брокерийн төлбөр, Зар сурталчилгааны зардлыг агуулсан борлуулалттай холбогдон гарах зардал
- Андеррайтингийн ашиг: Үйл ажиллагааны ашиг = Орлого (хураамж) – Зарлага (нэхэмжлэл)

Андеррайтингийн зардлын харьцаа

$$\text{Андер.н зардал} = \frac{\text{Андер.н нийт зардал}}{\text{Нийт хураамж}}$$

$$\text{Хосолсон харьцаа} = \frac{\text{Нийт хохирол} + \text{Зардал}}{\text{Нийт хураамж}}$$

$$\text{Хадгалалтын хувь} = \frac{\text{Шинэчилсэн гэрээний тоо}}{\text{Шинэчлэх боломжтой гэрээний тоо}}$$

Түлхүүр ойлголт : VII

- Давтамж :

$$\frac{\text{Нэхэмжлэлийн хязгаарын тоо}}{\text{Орлогод тооцсон хамралт}}$$

- Хэтрэлтийн зардал:

$$\frac{\text{Хязгаарын хохирол}}{\text{Орлогод тооцсон хамралт}}$$

- Учирсан дундаж зардал :

$$\frac{\text{Учирсан нэхэмжлэлийн дүн}}{\text{Учирсан нэхэмжлэлийн тоо}}$$

Нийт хураамжийн бүрэлдэхүүн:

- Нийт хураамж = Цэвэр эрсдлийн хураамж + Ачааллууд
 - Шимтгэл
 - Зардал
 - Ашиг
 - Бусад ачаалал

Хураамж тооцох ерөнхий томьёо:

$$GP = \frac{CF \times CA \times (1+h)+VE}{1-c-f-p}$$

GP=Нийт хураамж
CF=Хүлээгдэж буй нэхэмжлэлийн давтамж
CA=Хүлээгдэж буй нэхэмжлэлийн дундаж
с=Шимтгэлийн %
f=Тогтмол зардал, GP-аас %-р

VE=Нэг гэрээнд ногдох бусад хувьсах зардал
H =Нэхэмжлэл шийдвэрлэх зардал, CA-аас %-р
р=Ашиг ба бусад ачаалал, GP-аас %-р

9. ХӨНГӨЛӨЛТ

Хэрэв 2 жил тасралтгүй даатгуулсан даатгуулаад ингэхдээ нөхөн төлбөр гаргаж байгаагүй даатгуулагчид хамгаалах хамгаалалтын хэмжээг өсгөж, хураамжийн хэмжээг хэвээр байлгана.

ХАВСРАЛТУУД

10. НӨХӨН ТӨЛБӨРИЙН МАЯГТ

НӨХӨН ТӨЛБӨР АВАХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ ТОГТООХ МЭДҮҮЛГИЙН ХУУДАС

ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

Мэдүүлгийн хуудасыг бөглөхийн та өмнө дараах зүйлсийг анхааралтай уншина уу.

1. Гэрч нь 18 насанд хүрсэн, нөхөн төлбөр аваар нэрлэгдээгүй этгээд байна.

ХҮ даатгалын компанийн гэнэтийн ослын даатгалын гэрээгээр нөхөн төлбөр авах эрх бүхий этгээдийг томилохын өмнө доорх хүснэгтийг бөглөнө үү!

Даатгуулагчийн нэр:	
Даатгалын гэрээний дугаар:	
Даатгалын гэрээ эхлэх өдөр:	
Даатгалын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан хугацаа:	
Даатгалын гэрээ дуусгавар болох хугацаа:	

Миний бие доор бичигдсэн этгээдүүдийг өөрийнхөө нөхөн төлбөр авах этгээдээр томилохыг даатгалын гэрээнд заагдсаны дагуу хүлээн зөвшөөрч байна. Ингэснээр өмнө нь дурьдагдсан этгээдүүдийн нөхөн төлбөр авах эрх нь хүчингүй болно.

Эрх бүхий этгээдийн нэр	Иргэний үнэмлэх/ төрсний гэрчилгээ/ паспортын дугаар	Төрсөн он, сар, өдөр	Хаяг	Хамаарал	Хувь хэмжээ (%)

Даатгуулагчийн гарын үсэг:..... Гэрчийн гарын үсэг:.....

Нэр: Нэр:.....

Регистер/Паспортын №:..... Регистер/Паспортын №:.....

Огноо:..... Огноо:.....

Гэрийн хаяг:..... Гэрийн хаяг:.....

11. НӨӨЦ БҮРДҮҮЛЭЛТ

ДААГТГАЛЫН НӨӨЦ САН

Ердийн даатгалын компани нь СЗХ-с гаргасан “Ердийн даатгалын компанийн нөөц сан бүрдүүлэх, зарцуулах” журмын дагуу үндсэн 4 төрлийн нөөцийг бүрдүүлдэг.

1. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан

Даатгалын хураамжийн орлогын зохих хэсгийг ирээдүйд учирч болзошгүй эрсдэлд зориулж нөөцөлдөг. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан.

- Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан нь даатгуулагчид ирээдүйд төлөх нөхөн төлбөрийн нөөцийн хэсэг бөгөөд даатгагчийн үйл ажиллагааны зардал үүнд орсон байна.
- Орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг даатгагчийн хүлээн авсан даатгалын хураамжаас гэрээний үлдэх хугацаанд ногдуулан байгуулна.
- Орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг энэ журмын 3. 8-д зааснаас бусад тохиолдолд 8-тын аргаар тооцох бөгөөд улирлын даатгалын цэвэр хураамжийн орлогоос дараах байдлаар тооцно:
 - $ОТХ = ОТХ1 + ОТХ-1 + ОТХ-2 + ОТХ-3$
 - $ОТХ1 = ЦХ1 * 7/8$

- iii. $ОТХ-1=ЦХ-1 * 5/83.3.1. ОТХ-2=ЦХ-2 * 3/8$
- iv. $ОТХ-3=ЦХ-3 * 1/8$
- d. Энэ журмын 1.3-т заасан товчлолыг дараах агуулга бүхий тайлбараар тодорхойлж ойлгоно.
 - i. ОТХ- Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан;
 - ii. ОТХ1- Тайлант улирлын орлогод тооцоогүй хураамж;
 - iii. ОТХ-1- Тайлант улирлын өмнөх улирлын орлогод тооцоогүй хураамж;
 - iv. ОТХ-2- Тайлант улирлаас 2 улирлын өмнөх орлогод тооцоогүй хураамж;
 - v. ОТХ-3- Тайлант улирлаас 3 улирлын өмнөх орлогод тооцоогүй хураамж;
 - vi. ЦХ1- Тайлант улирлын цэвэр хураамжийн орлого;
 - vii. ЦХ-1- Тайлант улирлын өмнөх улирлын цэвэр хураамжийн орлого;
 - viii. ЦХ-2- Тайлант улирлаас 2 улирлын өмнөх цэвэр хураамжийн орлого;
 - ix. ЦХ-3- Тайлант улирлаас 3 улирлын өмнөх цэвэр хураамжийн орлого.

2. Учирсан боловч нэхэмжлээгүй /IBNR/ хохирлын нөөц сан

- a. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан гэдэгт тайлант хугацаанд нэхэмжилж болзошгүй хохиролд зориулан байгуулсан нөөц санг ойлгоно.
- b. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц санг тайлангийн жилээс өмнөх үеүдэд байгуулсан гэрээний дагуу даатгуулагчаас нэхэмжилж болзошгүй нөхөн төлбөрийг барагдуулахад зориулан байгуулна. Уг нөөц санг өмнөх санхүүгийн тайлангийн жилүүдийн нөхөн гүйцэтгэлийн хэмжээний талаарх бодит мэдээлэл дээр үндэслэн актуар тооцооллоор орлогод тооцсон хураамжаас санхүүгийн тайлангийн жилийн эцэс бүрт байгуулна.
- c. Тайлант жилээс өмнө байгуулсан даатгалын гэрээний дагуу даатгуулагчаас даатгалын нэхэмжлэл ирсэн тохиолдолд даатгуулагчийн нэхэмжилсэн дүнгээр уг нөөц сангаас нэхэмжилсэн хохирлын нөөц сан руу шилжүүлнэ.
- d. Даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг буруутай этгээдээр төлүүлэх тохиолдолд төлүүлсэн дүнгээр уг нөөц сангийн хөрөнгийг нэмэгдүүлнэ.
- e. Даатгалын тохиолдлын улмаас даатгуулагчийн даатгуулсан хөрөнгө бүрэн сүйрч улмаар даатгагч даатгуулсан хөрөнгийг өөрийн эзэмшил, өмчлөлд авсан тохиолдолд даатгагч уг хөрөнгийг учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сангийн хөрөнгөд бүртгэн авна.

3. Нэхэмжилсэн хохирлын нөөц сан

- a. Нэхэмжилсэн хохирлын нөөц сан гэдэгт даатгуулагчийн нэхэмжилсэн хохирлыг нөхөн төлөхөд зориулагдсан нөөц санг ойлгоно.
- b. Нэхэмжилсэн хохирлын нөөц санг даатгуулагчаас даатгалын нэхэмжлэл ирсэн тохиолдолд даатгуулагчийн нэхэмжилсэн дүнгээр учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан эсвэл орлогод тооцсон хураамжийг хорогдуулж байгуулна.

- c. Тайлант хугацаанд байгуулсан гэрээний дагуу даатгуулагчаас нэхэмжлэл ирсэн тохиолдолд орлогод тооцсон хураамжаас нэхэмжилсэн хохирлын нөөц санг байгуулна.
 - d. Даатгуулагчид олгох даатгалын нөхөн төлбөрийг нэхэмжилсэн хохирлын нөөц сангаас гаргана.
 - e. Даатгуулагчид олгосон нөхөн төлбөр нэхэмжилсэн хохирлын нөөц сангаас бага байвал зөрүүг нэхэмжилсэн хохирлын нөөц санг байгуулсан эх үүсвэр лүү буцаан шилжүүлнэ.
4. Учирч болзошгүй хохирлын нөөц сан
- a. Учирч болзошгүй хохирлын нөөц сан гэдэгт тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц санг ойлгоно.
 - b. Хэлбэр тус бүрийн хувьд даатгуулагчид олгохоор тооцоолсон нөхөн төлбөр нь орлогод тооцоогүй хураамжаас их байх тохиолдолд тэр зөрүүгээр учирч болзошгүй хохирлын нөөц санг орлогод тооцсон хураамжаас байгуулна.
 - c. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан болон орлогод тооцсон хураамжаас нэхэмжилсэн хохирлын нөөц санг байгуулахад хүрэлцэхгүй болсон тохиолдолд дутсан хэсгийг учирч болзошгүй хохирлын нөөц сангаас нэхэмжилсэн хохирлын нөөц сан руу шилжүүлнэ.
 - d. Учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан нь нэхэмжилсэн хохирлын нөөц санг бүрдүүлэхэд хүрэлцэхгүй тохиолдолд учирч болзошгүй хохирлын нөөц сангаас дутагдсан хэсгийг бүрдүүлэх ба хэрэв учирч болзошгүй хохирлын нөөц сан хүрэлцэхгүй болсон тохиолдолд орлогод тооцсон хураамжаас нэхэмжилсэн хохирлын нөөц сан луу шилжүүлнэ.
 - e. Орлогод тооцсон хураамжаас нэхэмжилсэн хохирлын нөөц санг бүрдүүлэхэд хүрэлцэхгүй болсон тохиолдолд дутагдсан хэсгийг учирч болзошгүй хохирлын нөөц сангаас нэхэмжилсэн хохирлын нөөц сан луу шилжүүлнэ.
 - f. Энэ журмын 3.1, 3.2-д заасны дагуу нэхэмжилсэн хохирлын нөөц санг бүрдүүлэх боломжгүй болсон тохиолдолд СЗХ-д мэдэгдэнэ. Учирч болзошгүй хохирлын нөөц сан
 - g. Учирч болзошгүй хохирлын нөөц сан гэдэгт тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц санг ойлгоно.
 - h. Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн хувьд учирч болзошгүй хохирлын нөөцийн санг дараах аргачлалаар улирал тутамд байгуулна. Үүнд:

ОТХ – аас олгосон нөхөн төлбөр + байгуулсан УБНХНС

$$\text{ОТХ} \diamond * 100\% < X \text{ үед}$$

$$\text{УБНХНС} = \diamond X - \diamond$$

ОТХ – аас олгосон нөхөн төлбөр + байгуулсан УБНХНС

$$\text{ОТХ} \diamond * 100\% \diamond \times$$

Энд,

“ОТХ” – орлогод тооцсон хураамж;

“УБНХНС”- учирсан боловч нэхэмжлээгүй хохирлын нөөц сан;

“УБХНС” –учирч болзошгүй хохирлын нөөц сан;

“Х” – Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын хэмжээ, даатгалын хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-ын 3.1.1-д заасан

“Даатгалын цэвэр хураамж”-ийн хувь.

Хэлбэр тус бүрийн хувьд даатгуулагчид олгохоор тооцоолсон нөхөн төлбөр нь орлогод тооцоогүй хураамжаас их байх тохиолдолд тэр зөрүүгээр учирч болзошгүй хохирлын нөөц санг орлогод тооцсон хураамжаас байгуулна.

5. Даатгалын нөөц санд тавих хяналт

- a. Даатгагч татан буугдсан, дампуурсан тохиолдолд даатгалын бүх нөхөн төлбөр, хураамжийн буцаалт хийгдсэний дараах нөөц сангийн үлдэгдлээс хорооноос томилсон актуарчдын актуар тооцооллын дагуу тохирох хэсгийг даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор даатгагчдын холбооны тусгайлсан дансанд байршуулна.
- b. Энэ журмын 5.1-д заасан тусгайлсан дансанд нөөц сангийн мөнгийг 5 жилийн хугацаанд байршуулж, зөвхөн даатгалын нөхөн төлбөрт зарцуулах ба хэрэгжилтэнд хороо байнгын хяналт тавина.
- c. Даатгалын нөөц сангийн хөрөнгийг зөвхөн тухайн сангийн зориулалтын дагуу зарцуулах бөгөөд хөрөнгийг хооронд нь шилжүүлэн зарцуулахыг хориглоно.
- d. Даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, зарцуулалтанд хороо улирал тутам хяналт тавина.
- e. Даатгалын нөөц сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг хорооноос зөвшөөрсөн маягтуудын дагуу гаргаж, улирал бүр хороонд ирүүлнэ.
- f. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

18. ХУУЛЬ, ЭРХЗҮЙН АКТУУД

ИРГЭНИЙ ХУУЛЬ

ДӨЧИН ГУРАВДУГААР БҮЛЭГ

Даатгал

431 дүгээр зүйл. Даатгалын гэрээ

431.1.Даатгалын гэрээгээр даатгагч нь даатгалын тохиолдол бий болоход даатгуулагчид учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх, даатгуулагч нь даатгалын хураамж төлөх үүргийг тус тус хүлээнэ.

431.2.Даатгалын зүйл нь эд хөрөнгө, иргэдийн амь нас, эрүүл мэнд, түүнчлэн хуульд харшлаагүй эдийн бус ашиг сонирхол байна.

431.3.Хуульд өөрөөр заагаагүй бол даатгалын гэрээг бичгээр хийх бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна.

/Энэ хэсэгт 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

431.4.Даатгалын гэрээнд дараахь нөхцөлийг тусгана:

431.4.1.даатгалын зүйл;

431.4.2.даатгалын эрсдэлийн төрөл;

431.4.3.даатгалын үнэлгээний хэмжээ;

431.4.4.даатгалын хугацаа, түүнийг дахин сунгах нөхцөл;

431.4.5.даатгалын хураамжийн хэмжээ, түүнийг төлөх хугацаа;

431.4.6.даатгагч, даатгуулагчийн эрх, үүрэг, хариуцлага;

431.4.7.гэрээг дүгнэх, цуцлах, түүнд өөрчлөлт оруулах нөхцөл.

432 дугаар зүйл. Даатгалын төрөл, хэлбэр

432.1.Даатгал нь сайн дурын болон албан журмын гэсэн төрөлтэй байна.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

432.2. албан журмын даатгалын хэлбэрийг хуулиар тогтооно.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

432.3.Энэ хуулийн 432.2-т зааснаас бусад даатгал сайн дурын даатгалд хамаарна.

433 дугаар зүйл. Даатгалын баталгаа

433.1.Даатгагч нь гарын үсэг зурсан даатгалын баталгааг даатгуулагчид гардуулах үүрэгтэй.

433.2.Даатгалын баталгааг тодорхой этгээдэд нэр заасан буюу мэдүүлгийн баталгааны хэлбэрээр олгосон бол даатгагч нь анхны даатгуулагчид тавих бүх шаардлагыг баталгаа эзэмшигчид гаргаж болно. Даатгалын баталгаа эзэмшигч нь даатгалтай холбогдсон эрхээ шилжүүлж байгаагаа даатгагчид мэдэгдсэн бөгөөд эрх шилжүүлэгч шаардлагаа нэн даруй гаргасан бол энэ журам хамаарахгүй.

433.3.Даатгуулагч гагцхүү даатгалын баталгаа үзүүлсэн тохиолдолд даатгагч үүргээ гүйцэтгэхээр гэрээнд заасан бөгөөд баталгааг алдаж үрэгдүүлсэн бол тусгай журмын дагуу уг баталгаа хүчингүй болсон тухай зарлан мэдэгдсэн тохиолдолд л даатгуулагч гэрээний биелэлтийг шаардах эрхтэй.

433.4.Даатгалын баталгааг алдаж үрэгдүүлсэн боловч энэ хуулийн 433.3-т заасны дагуу зарлуулсан бол даатгуулагч нь баталгааны хуулбар олгохыг даатгагчаас шаардаж болох бөгөөд хуулбар олгохтой холбогдсон зардлыг даатгуулагч хариуцна.

434 дүгээр зүйл. Даатгалын гэрээ дуусгавар болох үндэслэл

434.1.Даатгалын гэрээний хугацааг даатгагч, даатгуулагч харилцан тохиролцож тогтооно.

434.2. Даатгалын гэрээ дараахь тохиолдолд дуусгавар болно:

434.2.1. хууль, гэрээгээр тогтоосон хугацаа дуусгавар болсон;

434.2.2. даатгагч, даатгуулагчийн аль нэг дампуурсан, татан буугдсан;

434.2.3. шүүх гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;

434.2.4. даатгуулсан эд хөрөнгийг шүүхийн шийдвэрээр хураасан;

434.2.5. талууд тохиролцож гэрээг цуцалсан;

434.2.6. даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн.

435 дугаар зүйл. Даатгалын гэрээг цуцлах

435.1.Даатгалын гэрээг 5 жилээс илүү хугацаагаар байгуулсан бол нэг тал нь гэрээ цуцлах тухай нөгөө талдаа мэдэгдсэнээс хойш 3 сарын дараа цуцалж болно.

435.2.Даатгалын гэрээг нэг жилээс дээш хугацаагаар сунгах нөхцөлтэйгээр байгуулсан тохиолдолд талууд гэрээний хугацааг дуугүй хүлээн зөвшөөрөх замаар сунгах, даатгалын гэрээг хугацаанаас өмнө цуцлахгүй байх тохиролцоо хүчин төгөлдөр бус байна. Даатгуулагч гэрээг цуцлахдаа энэ хуулийн 435.1-д заасан хугацааг баримтлах үүрэгтэй.

435.3.Даатгагч даатгалын хураамжийг нэмэгдүүлсэн тохиолдолд даатгуулагч нь 1 сарын дотор гэрээг цуцалж болно.

436 дугаар зүйл. Гэрээ цуцалж болох ноцтой нөхцөл байдал

436.1.Даатгуулагч нь гэрээ байгуулахдаа өөрийн мэдэж байгаа аюул учруулах буюу даатгалын тохиолдол бий болоход нөлөөлж болох ноцтой нөхцөл байдал, түүнчлэн гэрээ байгуулснаас хойш бий болсон ийм нөхцөл байдлын талаар даатгагчид нэн даруй мэдээлэх үүрэгтэй.

436.2.Даатгагч нь гэрээнээс татгалзах буюу гэрээний агуулгыг өөрчлөх шийдвэр гаргахад нөлөөлж болох, түүнчлэн даатгагч нь даатгуулагчаас тодорхой, хоёрдмол утга санаагүйгээр шууд, бичгээр асуусан нөхцөл байдлыг ноцтойд тооцно.

436.3.Даатгуулагч энэ хуулийн 436.1-д заасан үүргээ биелүүлээгүй бол даатгагч нь гэрээнээс татгалзах, эсхүл энэ тухай мэдсэнээс хойш 1 сарын дотор гэрээг цуцлах буюу даатгалын хураамжийг зохих хэмжээгээр нэмэгдүүлэхийг шаардах эрхтэй. Харин даатгуулагч аюулыг санаатайгаар ихэсгэсэн бол даатгагч гэрээг хэдийд ч цуцалж болно.

436.4.Даатгуулагч энэ хуулийн 436.2-т заасан ноцтой нөхцөл байдлын тухай мэдээлэх гэж байхад даатгагч санаатайгаар зайлсхийсэн, эсхүл даатгагч тухайн нөхцөл байдлын талаар мэдэж байсан бол энэ хуулийн 436.3-т заасан журам үйлчлэхгүй.

436.5.Ноцтой нөхцөл байдлын тухай мэдээнд буруу ташаа баримт дурдсан бол даатгагч гэрээнээс татгалзаж болох бөгөөд даатгагч энэ мэдээ баримтын буруу ташааг мэдэж байсан, эсхүл ийм мэдээ ирүүлсэнд даатгуулагч буруугүй бол гэрээнээс татгалзах эрхгүй.

436.6.Даатгуулагч аюул учрах нөхцөл байдлын тухай бичгээр мэдээлэх үүргээ санаатайгаар биелүүлээгүй бол даатгагч гэрээг цуцлах эрхтэй.

436.7.Даатгалын тохиолдол бий болсноос хойш даатгагч гэрээ цуцлахаар мэдэгдсэн бөгөөд даатгуулагч ноцтой нөхцөл байдлын талаар заавал мэдээлэх үүргээ биелүүлээгүй нь даатгалын тохиолдол бий болох болон даатгагчаас үүргээ биелүүлэхэд нөлөөлөөгүй бол даатгагч үүргээс чөлөөлөгдөхгүй.

437 дугаар зүйл. Даатгалын хураамж төлөх үүрэг

437.1.Даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй бол даатгагч хураамж төлөх 15 хоногийн нэмэлт хугацаа тогтоож болох бөгөөд энэ хугацааг дахин хэтрүүлбэл үүсэх үр дагаврыг даатгагч бичгээр мэдэгдэнэ.

437.2.Даатгуулагч даатгалын хураамжийг хугацаанд нь төлөөгүй байхад даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч гэрээнд заасан үүрэг хүлээхгүй.

437.3.Даатгалын тохиолдол бий болохоос өмнө даатгуулагч даатгалын гэрээнээс татгалзсан бол даатгагч эрсдэлийг өөртөө хүлээж байсан хугацаанд тохирох даатгалын хураамж болон гэрээний дагуу үзүүлсэн үйлчилгээнийхээ хөлсийг даатгуулагчаас шаардах эрхтэй.

437.4.Даатгагчийн төлбөрийн чадвар үлэмж доройтож, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахааргүй нөхцөл бий болсон бол даатгуулагч даатгалын хураамж төлөхөөс татгалзах эрхтэй.

438 дугаар зүйл. Даатгалын үнэлгээний хэмжээ

438.1.Даатгалын үнэлгээний хэмжээг талууд харилцан тохиролцож тодорхойлно.

438.2.Эд хөрөнгийг даатгах тохиолдолд даатгагч эд хөрөнгийг үзэж үнэлгээний хэмжээг тогтоох эрхтэй.

438.3.Эд хөрөнгийн даатгалын үнэлгээний хэмжээ түүний өртгөөс илүүгүй байна.

438.4.Гэрээнд заасан даатгалын үнэлгээний хэмжээ даатгуулсан эд хөрөнгийн өртгөөс илүү байвал эд хөрөнгийн өртгөөс илүү гарсан хэсэгт нь гэрээ хүчин төгөлдөр бус байна.

438.5.Гэрээнд заасан даатгалын үнэлгээний хэмжээ эд хөрөнгийн өртгөөс бага байвал даатгалын тохиолдол бий болоход даатгагч даатгуулагчид учирсан хохирлыг даатгуулсан эд хөрөнгийн өртөгт даатгалын үнэлгээний хэмжээг хувь тэнцүүлэн бодож нөхөн төлбөр олгоно.

438.6.Даатгалын гэрээгээр энэ хуулийн 438.5-д зааснаас илүү хэмжээгээр нөхөн төлбөр төлөхөөр зааж болох боловч энэ нь даатгалын үнэлгээний хэмжээнээс хэтэрч болохгүй.

438.7.Даатгалын гэрээнд заасан бол даатгалын тохиолдол бий болсны улмаас олж чадаагүй ашиг, орлогыг даатгалын үнэлгээний хэмжээнд хамааруулж болно.

438.8.Даатгалын үнэлгээний хэмжээ даатгуулсан эд хөрөнгийн өртгөөс үлэмж их болох нь тогтоогдвол даатгагч даатгалын үнэлгээний хэмжээг бууруулах, даатгуулагч хураамжийг багасгахыг тус тус шаардах эрхтэй.

438.9.Даатгуулагч даатгалын үнэлгээний хэмжээг зориуд өсгөсөн бол гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцох бөгөөд энэ байдлыг даатгагч гэрээ байгуулах үедээ мэдээгүй байсан бол гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцохоос өмнө даатгуулагчийн төлсөн хураамж даатгагчид үлдэнэ.

439 дүгээр зүйл. Даатгалын тохиолдол бий болох үед даатгагч, даатгуулагчийн хүлээх үүрэг

439.1.Даатгуулагч даатгалын тохиолдол бий болсон тухай даатгагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

439.2.Даатгалын тохиолдол бий болсон үед даатгагч даатгалын тохиолдол буюу нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай аливаа мэдээг даатгуулагчаас шаардах эрхтэй.

439.3.Даатгуулагч даатгалын тохиолдол бий болсныг мэдээлэх үүргээ биелүүлээгүй боловч энэ нь даатгагчийн ашиг сонирхолд ноцтой хохирол учруулаагүй бол даатгагч үүргээс чөлөөлөгдөхгүй.

439.4.Даатгалын тохиолдол бий болж, даатгагчийн төлбөл зохих нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосны дараа даатгагч үүргээ гүйцэтгэх үүрэгтэй.

439.5.Даатгуулагч нь даатгалын тохиолдол бий болох үед аюулыг зайлуулах буюу хохирлыг багасгах арга хэмжээг даатгагчийн өгсөн зааврын дагуу авах бөгөөд үүнтэй холбогдон гарсан зардлыг даатгагч хариуцна.

440 дүгээр зүйл. Даатгалын төлөөлөгчийн эрх

440.1.Даатгалын төлөөлөгч даатгалын гэрээ байгуулах эрхтэй.

440.2.Даатгалын төлөөлөгчид даатгалын гэрээ байгуулах эрх олгосон бол гэрээний нөхцөлийг өөрчлөх, хугацааг сунгах буюу гэрээг цуцалж болно.

441 дүгээр зүйл. Бусад этгээдэд ашигтайгаар даатгах даатгал

441.1.Даатгуулагч өөрийн нэрийн өмнөөс бусад этгээдэд ашигтайгаар даатгалын гэрээ байгуулж болох бөгөөд энэхүү гэрээний үндсэн дээр үүсэх бүхий л эрхийг ашиг сонирхол нь даатгагдсан этгээд /цаашид “ашиг сонирхол бүхий этгээд”-гэх/ эдлэх боловч даатгалын баталгаа олгохыг гагцхүү даатгуулагч шаардах эрхтэй.

441.2.Ашиг сонирхол бүхий этгээд зөвхөн даатгалын баталгааг өөртөө авсан тохиолдолд даатгуулагчтай зөвшилцөхгүйгээр гэрээнд заасан эрхээ эдлэх буюу ийнхүү эрхээ хэрэгжүүлэхээр шүүхэд хандах эрхтэй.

441.3.Даатгагч даатгуулагчид даатгалын баталгаа олгосон бол даатгуулагч ашиг сонирхол бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр гэрээ ёсоор эдлэх аливаа эрхийг эдлэх, гэрээнд зааснаар шагнал авах, эсхүл ашиг сонирхол бүхий этгээд даатгалын баталгаа авсан нөхцөлд түүнд эрхийг нь шилжүүлэх эрхтэй.

441.4.Ашиг сонирхол бүхий этгээд даатгалын гэрээг хүлээн зөвшөөрч байгааг даатгуулагч нотолсон тохиолдолд даатгагч ашиг сонирхол бүхий этгээдийн төлөө нөхөн төлбөр гүйцэтгэх үүрэгтэй.

442 дугаар зүйл. Нийгмийн даатгал

442.1.Нийгмийн даатгалын төрөл, хэлбэрийг хуулиар тогтооно.

442.2.Нийгмийн даатгалтай холбогдон үүсэх харилцааг хуулиар зохицуулна.

443 дугаар зүйл. Гэм хорын даатгал

443.1.Гэм хорын даатгалаар даатгагч нь даатгуулагчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, эд хөрөнгийн бус ашиг сонирхолд учирсан гэм хорыг даатгалын үнэлгээний хэмжээгээр мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх үүрэг хүлээнэ.

443.2.Иж бүрдэл бүхий эд хөрөнгө даатгуулсан бол түүний бүрэлдэхүүнд багтах бүх эд хөрөнгөд даатгал нэгэн адил хамаарна.

443.3.Төлсөн даатгалын хураамж нь даатгалын тохиолдол бий болоход учирсан хохирлоос илүү эсэхээс үл хамааран даатгагч даатгуулагчид учирсан хохирлын хэмжээгээр нөхөн төлбөр төлнө.

443.4.Даатгуулагч нэг ашиг сонирхлыг хэд хэдэн даатгагчид нэгэн зэрэг даатгуулсан бол энэ тухай даатгагч бүрд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

443.5.Энэ хуулийн 443.4-т заасан тохиолдолд даатгалын үнэлгээний хэмжээ нь нийлбэр дүнгээрээ даатгуулсан эд хөрөнгийн өртгөөс давсан буюу өөр шалтгаанаар хохирлыг нөхөн төлөх хэлбэрээр олгох мөнгө нь нийлбэр дүнгээрээ хохирлын хэмжээнээс давж байвал даатгагчид хамтран үүргээ биелүүлнэ. Энэ тохиолдолд даатгуулагч хохирлын хэмжээнээс давсан нөхөн төлбөр шаардах эрхгүй.

443.6.Тусгай гэрээнд заасан тохиолдолд дайны үед учирсан гэм хорыг даатгагч хариуцна.

443.7.Даатгуулагч учирсан гэм хорыг нөхөн төлөх шаардлагыг гуравдагч этгээдэд гаргаж болох тохиолдолд даатгагч уг гэм хорыг даатгуулагчид нөхөн төлснөөр шаардах эрх даатгагчид шилжинэ. Харин даатгуулагч гуравдагч этгээдэд шаардлага гаргах буюу шаардлагыг хангуулах эрхээсээ татгалзсан бол тэр хэмжээгээр даатгагч гэм хорыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөгдөнө.

443.8.Хохирлыг нөхөн төлүүлэхээр шаардах даатгуулагчийн эрх нь түүнтэй хамт амьдран суугаа гэр бүлийн гишүүнд хамааралтай бол уг гишүүн санаатай хохирол учруулснаас бусад тохиолдолд түүний зөвшөөрөлгүйгээр шаардах эрхийг шилжүүлж болохгүй.

443.9.Даатгуулсан эд хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлсэн бол даатгуулагчийн эрх шинэ өмчлөгчид шилжинэ. Эд хөрөнгө ийнхүү шилжсэнийг даатгуулагч болон шинэ өмчлөгч даатгагчид нэн даруй мэдэгдэнэ.

443.10.Даатгуулагч болон шинэ өмчлөгч энэ хуулийн 443.9-т заасан үүргээ биелүүлээгүй тухай даатгагч мэдвэл зохих байсан үеэс хойш 1 сар өнгөрсний дараа даатгалын тохиолдол бий болсон бол даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөнө.

443.11.Даатгагч гэрээг цуцлах 1 сарын хугацааг баримтлан эд хөрөнгийн шинэ өмчлөгчтэй даатгалын харилцаагаа дуусгавар болгох эрхтэй.

443.12.Энэ хуулийн 443.9-т зааснаар эд хөрөнгө өөр этгээдэд шилжсэнийг даатгагч мэдсэнээс хойш 1 сарын дотор шинэ өмчлөгчтэй даатгалын гэрээг дуусгавар болгох эрхээ хэрэгжүүлээгүй бол уг эрх хүчингүй болно.

443.13.Даатгалын эрх шилжүүлэн авсан этгээд нэн даруй буюу даатгалын тухайн үе дуусахад даатгалын гэрээг цуцлах эрхтэй.

443.14.Шинэ өмчлөгч эд хөрөнгө шилжүүлэн авахдаа даатгалын гэрээний тухай мэдээгүй бөгөөд энэ тухай мэдсэнээс хойш 1 сарын дотор гэрээ цуцлах эрхээ хэрэгжүүлээгүй бол уг эрх нь хүчингүй болно.

443.15.Гэрээг энэ хуулийн 443.11, 443.13-т заасан үндэслэлээр цуцалсан бол эд хөрөнгийн эрхээ шилжүүлсэн даатгуулагч даатгагчид даатгалын хураамж төлөх үүрэгтэй бөгөөд хураамж нь гэрээ цуцлах үеийг оролцуулан тооцсон гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байсан хугацаанд төлбөл зохих хэмжээнээс хэтрэхгүй. Энэ тохиолдолд эрх шилжүүлэн авсан этгээд даатгалын хураамж төлөх үүрэг хүлээхгүй.

443.16.Гуравдагч этгээдийн ашиг сонирхлын төлөө амь нас даатгах гэрээ байгуулах тохиолдолд уг этгээд буюу түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлийг бичгээр авна.

443.17.Амь насаа даатгуулсан этгээд амиа хорлосон бол даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөнө.

443.18.Гуравдагч этгээдэд ашигтайгаар амь нас даатгасан тохиолдолд даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий гуравдагч этгээдийн хууль бус үйлдлийн улмаас даатгагдсан этгээд нас барсан бол уг этгээд даатгалын нөхөн төлбөр авах эрхээ алдана.

443.19.Даатгалтай холбоотой шаардлагыг хангах шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэж байгаа буюу даатгагч дампуурсантай холбоотой хэргийг хянан шийдвэрлэж байгаа бол даатгалын гэрээнд нэр заагдсан даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд даатгуулагчийн оронд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхтэй. Даатгуулагч дампуурсантай холбоотойгоор даатгалын гэрээ цуцлагдсан нөхцөлд даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд нь даатгагчаас шаардвал зохих мөнгөний хэмжээгээр дампуурлын үед даатгуулагчийн бусдад хуваарилагдах хөрөнгийг бүрдүүлэхэд оролцох үүрэгтэй.

443.20.Хэрэв даатгалын нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд энэ хуулийн 443.19-д заасан эрхийг эдлэх сонирхолгүй буюу гэрээнд даатгалын нөхөн төлбөр авах этгээдийн нэрийг заагаагүй бол даатгуулагчийн хууль ёсны өв залгамжлагч уг эрхийг эдэлж болно.

444 дүгээр зүйл. Хариуцлагын даатгал

444.1.Хариуцлагын даатгалаар даатгагч нь даатгалын хугацаанд үүсэх хариуцлагатай холбоотойгоор гуравдагч этгээдийн өмнө хүлээх үүргээс даатгуулагчийг чөлөөлөх үүрэгтэй.

444.2.Гуравдагч этгээд өөрт учирсан гэм хорыг нөхөн төлүүлэхээр даатгагчид шууд шаардлага гаргасан бол даатгагч гэрээгээр хүлээсэн үүргийн хэмжээнд уг гэм хорыг арилгах үүрэг хүлээнэ.

444.3.Гуравдагч этгээдийн шаардлагаас өөрийгөө хамгаалах зорилгоор гаргасан шүүхийн болон шүүхийн бус бусад зардлыг хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан зайлшгүй нөхөн төлөх шаардлагатай бол энэхүү зардал даатгалд нэгэн адил хамаарна.

444.4.Гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээхэд хүргэсэн нөхцөл байдлыг даатгуулагч санаатай бий болгосон бол даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөнө.

444.5.Даатгагч даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээсээ бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдсөн байсан ч албан журмаар даатгах даатгалын хувьд даатгагчийн гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага хүчин төгөлдөр байна.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

444.6.Энэ хуулийн 444.5-д заасан үүргийнхээ дагуу даатгагч нь гуравдагч этгээдийн шаардлагыг хангасан бол гуравдагч этгээдээс даатгуулагчид гаргах шаардлага даатгагчид шилжинэ.

ДААТГАЛЫН ТУХАЙ

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Нийгмийн даатгалын болон иргэний эрүүл мэндийн даатгалын харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“даатгалын үйл ажиллагаа” гэж даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагааг;

4.1.2.“даатгагч” гэж энэ хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийг;

4.1.3.“даатгуулагч” гэж өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулж, даатгагчтай гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийг;

4.1.4.“даатгалын тохиолдол” гэж даатгуулсан зүйлд учирсан хохирол, тохиролцсон болзол бүрдэхийг;

4.1.5.“даатгалын хураамж” гэж даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг;

4.1.6.“даатгалын нөхөн төлбөр” гэж гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгийг;

4.1.7.“даатгалын багц дүрэм” гэж энэ хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах зорилгоор гаргаж буй дүрэм, журам, заавар, нөхцөл, шаардлагыг;

4.1.8.“актуарч” гэж даатгагчийн төлбөрийн чадварын түвшин, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор учирч болзошгүй эрсдлийг урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн тооцоо, судалгааны үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг этгээдийг;

4.1.9.“давхар даатгалын үйл ажиллагаа” гэж даатгагч нь даатгуулагчийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн буюу хэсэгчлэн дахин даатгахыг;

4.1.10.“гадаадын зохицуулах байгууллага” гэж даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий гадаад улсын байгууллагыг;

4.1.11.“эрх бүхий албан тушаалтан” гэж Компанийн тухай хуулийн 81.1-д заасан этгээдийг.

4.1.12. “холбогдох этгээд” гэж даатгагч болон даатгалын үйл ажиллагаа эрхэлж байсан, тэдэнд хувьцааны хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд, уг хуулийн этгээдийн хувьцааны хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд болон Компанийн тухай хуулийн 97.1-д заасан нэгдмэл сонирхолтой этгээдийг.

4.2.Давхар даатгалын үйл ажиллагаанд энэ хуулийн 4.1.1 дэх заалт нэгэн адил хамаарна.

4.3.Бодит хохирлоос үл хамааран тодорхой итгэлцүүр буюу бусад аргачлалыг ашиглан даатгагчийн хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг томъёогоор дундажлан тооцоолж гаргадаг үйл ажиллагаа энэ хуулийн 4.1.1-д нэгэн адил хамаарна.

5 дугаар зүйл. Гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүний даатгал

5.1. Гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгө, эдийн бус хөрөнгөө Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн нэгэн адил нөхцөлөөр даатгуулах эрхтэй.

7 дугаар зүйл. Даатгалын хураамж

7.1. албан журмын даатгалын хураамжийн хэмжээг Монгол Улсын хуулиар тогтооно.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

7.2.Сайн дурын даатгалын хураамжийн хэмжээг энэ хуулийн 14.2.5-д заасан аргачлалын дагуу даатгагч тогтооно.

8 дугаар зүйл. Даатгалын нөхөн төлбөр

8.1.Даатгагч нь хууль болон гэрээнд заасан нөхцөлийн дагуу энэ хуулийн 8.4-т заасан баримтыг үндэслэн даатгуулагчид даатгалын нөхөн төлбөрийг олгоно.

8.2.Даатгалын гэрээнд заасан тохиолдолд нөхөн төлбөрийг даатгуулагчийн буруугаас хохирсон гуравдагч этгээдэд шууд олгож болно.

8.3.Даатгуулагч нас барсны дараа даатгалын тохиолдол үүссэн бол даатгалын нөхөн төлбөрийг түүний хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид олгоно.

8.4.Даатгалын нөхөн төлбөрийг дараахь баримтыг үндэслэн олгоно:

8.4.1.даатгуулагчийн өргөдөл;

8.4.2.даатгалын баталгааны эх хувь;

8.4.3.учирсан хохирлын тухай хохирол үнэлэгчийн бичгээр гаргасан дүгнэлт, акт материал;

8.4.4.шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, тодорхойлолт.

8.5.Даатгагч дараахь үндэслэлээр нөхөн төлбөрийг бүрэн буюу түүний зарим хэсгийг олгохоос татгалзаж болно:

8.5.1.даатгуулагч санаатайгаар хохирол учруулсан буюу даатгалын тохиолдол бий болох нөхцөл, орчныг бүрдүүлсэн;

8.5.2.даатгуулагч даатгалын зүйлийн талаар даатгагчид худал мэдээлсэн, хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

8.5.3.даатгалын гэрээнд зааснаас бусад шалтгаанаар хохирол гарсан;

8.5.4.гарсан хохирлыг даатгуулагч буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн;

8.5.5.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

8.6.Даатгагч нь нөхөн төлбөр олгохоос татгалзсан үндэслэлээ тодорхой гаргаж, даатгуулагчид бичгээр мэдэгдэнэ.

8.7.Даатгалын гэрээнд заасан бол буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх даатгуулагчийн эрх нь даатгалаар олгогдсон нөхөн төлбөр, түүнтэй холбогдон гарсан зардлын хэмжээгээр даатгагчид шилжинэ.

9 дүгээр зүйл. Даатгагчийн эрх, үүрэг

9.1.Даатгагч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

9.1.1.энэ хуулийн 8.5-д заасан үндэслэлийн дагуу даатгалын нөхөн төлбөрийг бүрэн буюу хэсэгчлэн олгохоос татгалзах;

9.1.2.даатгуулагчийн эрх, үүрэг нь шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд даатгагч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг шинэ эзэмшигчид тавих;

9.1.3.даатгуулагч хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;

9.1.4.даатгалын тохиолдол болсон үед нөхөн төлбөрийг хууль болон гэрээгээр тохиролцсон хугацаа, хэмжээнд олгох;

9.1.5.даатгалын баталгааг гэрээнд заасан хугацаанд даатгуулагчид олгох;

9.1.6.даатгалын хууль тогтоомж, гэрээний нөхцөлийг даатгуулагчид танилцуулах;

9.1.7.Монгол Улсын хуулиар зөвшөөрснөөс бусад нөхцөлд даатгуулагчийн талаархи мэдээ, материалын нууцыг задруулахгүй байх;

9.1.8.даатгалын эрсдэлийн улмаас учирч болох хохирлын хэмжээг багасгах зорилгоор даатгуулагчийн авсан арга хэмжээний өртгийг даатгуулагчид нөхөн төлөх;

9.1.9.даатгуулагч нас барсан тохиолдолд түүний эрх, үүргийг хууль ёсны буюу гэрээслэлээр өв залгамжлагчид нь шилжүүлэх;

9.1.10.гэрээний хугацаанд даатгуулагч эрх зүйн чадамжгүй нь тогтоогдвол түүний эрх, үүргийг хэрэгжүүлэхийн тулд хууль ёсны асран хамгаалагчийг шүүхээр тогтоолгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

9.1.11.Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу санхүүгийн тайлангийн хураангуйг хэвлэлд нийтлэх.

10 дугаар зүйл. Даатгуулагчийн эрх, үүрэг

10.1.Даатгуулагч дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

10.1.1.даатгалын тохиолдол болсон үед гэрээний нөхцөлийн дагуу нөхөн төлбөр олгохыг даатгагчаас шаардах;

10.1.2.даатгагч хууль болон гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, эсхүл түүнд өөрчлөлт оруулахыг шаардах;

10.1.3.даатгуулагчийн эрх, үүрэг шинэ эзэмшигчид шилжих тохиолдолд шинэ эзэмшигч гэрээнд өөрчлөлт оруулах саналыг даатгагчид тавих;

10.1.4.даатгалын хураамжийг хууль болон гэрээнд заасан хугацаанд даатгагчид төлөх;

10.1.5.даатгалын зүйлийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, даатгалын тохиолдол болсон үед хохирлыг багасгах зорилгоор бололцоотой арга хэмжээг авах, даатгагчид нэн даруй мэдэгдэх;

10.1.6.даатгал хийлгэхтэй холбогдсон баримт материалыг даатгагчид үнэн зөв гаргаж өгөх.

17 дугаар зүйл. Даатгагчийн даатгах хөрөнгө

17.1.Монгол Улсад оршин суугч хувь хүн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт буй эд хөрөнгөө гагцхүү энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчид даатгуулна.

17.2.Энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулж болох бөгөөд гэрээ байгуулах тохиолдол бүрт Зохицуулах хорооноос зөвшөөрөл авна.

ДАВХАР ДААТГАЛ

46 дугаар зүйл. Давхар даатгалд даатгуулах

46.1.Даатгагч нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ дараахь даатгагчид даатгуулж болно:

46.1.1.энэ хуулийн дагуу давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанид;

46.1.2.энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй гадаад улсын даатгалын компанид.

47 дугаар зүйл. Даатгагчийн давхар даатгалын гэрээ

47.1.Даатгагч даатгалын эрсдлийг хариуцах үүргээ давхар даатгуулах төлөвлөгөөг даатгалын багц дүрэмд заасны дагуу Зохицуулах хороогоор батлуулна.

47.2.Зохицуулах хороо тухайн төрлийн давхар даатгалын гэрээнд энэ хуулийн 47.1-д заасан давхар даатгалын төлөвлөгөөг батлуулахад тавигдах шаардлага хамаарахгүй байхаар бичгээр тогтоож болно.

48 дугаар зүйл. Давхар даатгалын тайлан

48.1.Даатгагч нь давхар даатгалын төлөвлөгөөний нарийвчилсан тайланг тогтоосон хугацаанд гаргаж Зохицуулах хороонд хүргүүлэх бөгөөд тайланд давхар даатгалын гэрээний хуулбарыг хавсаргана.

АРАВДУГААР БҮЛЭГ

Даатгагчийн үүрэг, даатгагчид тавих хязгаарлалт

49 дүгээр зүйл. Даатгагч зөвхөн даатгалын үйл ажиллагаа эрхлэх

49.1.Даатгагч нь Монгол Улсад болон гадаад улсад гагцхүү даатгалын үйл ажиллагаа болон түүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлнэ.

49.2.Даатгагчийн эрхлэх даатгалтай холбоотой үйл ажиллагааг даатгалын багц дүрмээр тодорхойлно.

Зах зээлийн ёс зүй

58 дугаар зүйл. Төөрөгдүүлсэн зар сурталчилгаа

58.1.Даатгагч нь төөрөгдүүлсэн, эсхүл худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа, мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглоно.

58.2.Даатгагчийн болон түүний нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл Зохицуулах хороо тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, няцаахыг даалгах, эсхүл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийж гаргахыг бичгээр даалгана.

59 дүгээр зүйл. Зах зээлийн ёс зүй

59.1.Зохицуулах хороо даатгагчийн дагаж мөрдвөл зохих зах зээлийн ёс зүйн журмыг гаргаж болох бөгөөд даатгагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон даатгалын үйл ажиллагаанд оролцогч түүнийг дагаж мөрдөх үүрэгтэй.

70.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Зохицуулах хороонд бичгээр ирүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно.

70.4.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд дараахь агуулга бүхий мэдэгдлийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр хүргүүлнэ:

70.4.1.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай;

70.4.2.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэл, огноо.

71 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос үүсэх үр дагавар

71.1.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш даатгагч Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дараахь үйлдэл хийхийг хориглоно:

71.1.1.шинээр даатгалын гэрээ байгуулах;

71.1.2.тухайн өдрөөс өмнө байгуулсан даатгалын гэрээг шинэчлэх, өөрчлөх.

71.2.Шаардлагатай гэж үзвэл даатгагч нь даатгалын гэрээгээр хүлээсэн үүрэг, давхар даатгалын хураамжийн төлбөр болон гэрээнээс үүссэн бусад зардлыг төлөх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.

71.3.Зохицуулах хороо тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон талаархи мэдээллийг даатгалын багц дүрэмд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

72 дугаар зүйл. Зохицуулах хороо даатгагчийн эд хөрөнгийг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах

72.1.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон, эсхүл энэ хуулийн 69.1, 70.1-д заасан үндэслэл байна гэж үзвэл нийтийн болон зээлдүүлэгч, даатгуулагчийн ашиг сонирхол, даатгагчийн өмч хөрөнгө, үйл ажиллагааг хамгаалах зорилгоор Зохицуулах хороо шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

72.2.Зохицуулах хороо энэ хуулийн 72.1-д заасан нэхэмжлэл гаргахдаа даатгагчид мэдэгдэх үүрэг хүлээхгүй.

72.3.Даатгагчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлээгүй, эсхүл хүчингүй болгоогүй бол нэхэмжлэлийг энэ хуулийн 69.5, 70.2-т заасан тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгох тухай мэдэгдлийг даатгагчид өгөхөөс өмнө гаргаж болно.

72.4.Энэ хуулийн 72.1-д заасан нэхэмжлэлийн дагуу шүүх дараахь арга хэмжээг хэрэгжүүлж болно:

72.4.1.даатгагч болон бусад этгээдийн эзэмшилд буй өмч хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах зэрэг хэлцэл хийхийг хориглосон шийдвэр гаргах;

72.4.2.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгохоос өмнө даатгагчийн үйл ажиллагааг удирдан зохицуулах бүрэн эрхт төлөөлөгчийг нэн даруй томилох;

72.4.3.компанийг татан буулгах;

72.4.4.даатгагчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл авахаар холбогдох этгээдийг дуудан ирүүлэх.

72.5.Шүүх энэ хуулийн 72.4.2-т заасан бүрэн эрхт төлөөлөгчийг томилохдоо түүний эрх хэмжээ, цалин хөлс, шүүх болон Зохицуулах хороонд тайлан мэдээ гаргаж өгөх журмыг тогтооно.

72.6.Шүүх бүрэн эрхт төлөөлөгчийн талаар дараахь арга хэмжээг хэдийд ч авч болно:

72.6.1.эрх үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан даалгавар, зааварчилга өгөх;

72.6.2.эрх хэмжээг нь өөрчлөх;

72.6.3.бүрэн эрхийг нь дуусгавар болгох.

73 дугаар зүйл. Даалгавар

73.1.Зохицуулах хороо даатгагчид албадлагын арга хэмжээ авахдаа дараахь агуулга бүхий даалгаврыг өгч болно:

73.1.1.даатгалын тодорхой ангилал, төрөл, хэлбэрийн үйл ажиллагаа эрхлэхийг түр зогсоох;

73.1.2.даатгалын тодорхой ангилал, төрөл, хэлбэртэй холбоотой шинээр гэрээ байгуулахыг хориглох;

73.1.3.байгуулсан даатгалын гэрээг өөрчлөхийг хориглох;

73.1.4.даатгалын нийт хураамжийн хэмжээг даалгаварт заасан хэмжээгээр тогтоох;

73.1.5.тодорхой төрлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахыг хориглох;

73.1.6.тодорхой хугацааны дотор өөрийн эзэмшилд буй хөрөнгө оруулалтыг чөлөөлөх;

73.1.7.хуульд заасан хугацаанаас өмнө санхүүгийн хяналт шалгалт хийх, шалгалттай холбогдуулан актуарч болон бусад этгээдийг томилох;

73.1.8.шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын багц дүрэмд зааснаас богино хугацаанд гаргаж өгөх;

73.1.9.бизнес төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

73.1.10.даатгуулагч болон хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

/Энэ заалтад 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

73.2.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон бол шаардлагатай гэж үзсэн бусад даалгаврыг өгч болно.

73.3.Энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу Зохицуулах хорооноос өгч буй аливаа даалгаврыг даатгагч биелүүлэх үүрэгтэй.

73.4.Тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон этгээдэд энэ хуулийн 73 дугаар зүйл нэгэн адил хамаарна.

74 дүгээр зүйл. Шалгагчийг томилох

74.1.Зохицуулах хороо энэ хуулийн 67.1-д заасан үндэслэлээр албадлагын арга хэмжээ авахдаа тухайн этгээдийн үйл ажиллагааг хянан шалгах үүрэг бүхий нэг буюу хэд хэдэн этгээдийг шалгагчаар томилж болно.

74.2.Энэ хуулийн 74.1-д заасны дагуу томилогдсон шалгагч нь дараахь асуудлыг хянан шалгаж болно:

- 74.2.1.даатгагчийн үйл ажиллагаа, түүний шинж чанар;
- 74.2.2.даатгагчийн үйл ажиллагааны тодорхой асуудлууд;
- 74.2.3.даатгагчийн болон хувьцаа эзэмшигчдийн хяналт.

/Энэ заалтад 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

74.3.Шалгагч нь шаардлагатай гэж үзвэл тухайн этгээдийн үйл ажиллагаа болон компанийн нэгдлийн бусад гишүүдийн үйл ажиллагааг хэдийд ч шалгаж болно.

74.4.Шалгагчийн томилолтын хугацаа болон нөхцөлийг Зохицуулах хороо өөрийн үзэмжээр тогтооно.

АРВАНТАВДУГААР БҮЛЭГ **Даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх, нэгтгэх**

75 дугаар зүйл. Даатгалын үйл ажиллагааг шилжүүлэх болон нэгтгэх

75.1.Даатгагч даатгалын үйл ажиллагаагаа шилжүүлэх болон нэгтгэх хүсэлтээ Зохицуулах хороонд гаргаж бичгээр зөвшөөрөл авна.

75.2.Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд даатгагчид дараахь зүйлийг хориглоно:

75.2.1.даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг бусад этгээдэд шилжүүлэх;

75.2.2.даатгагчийн үйл ажиллагааны аливаа хэсгийг бусад этгээдийн үйл ажиллагаатай нэгтгэх.

75.3.Энэ хуулийн 75 дугаар зүйлд заасны дагуу шилжүүлэх болон нэгтгэх тухай өргөдөл гаргах, өргөдлийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон үйл ажиллагааг даатгалын багц дүрмээр зохицуулна.

75.4.Шилжүүлэх болон нэгтгэх тухай зөвшөөрлийг олгохоос өмнө Зохицуулах хороо дараахь арга хэмжээг авч болно:

75.4.1.шилжүүлэх болон нэгтгэх нь зохимжтой эсэх талаар судлах;

75.4.2.даатгагч болон бусад этгээдээс шаардлагатай гэж үзсэн баримт бичиг, мэдээллийг шаардаж авах.

75.5.Энэ хуулийн 75.4.1-д заасныг Зохицуулах хороо буюу түүний эрх олгосон этгээд хэрэгжүүлэх бөгөөд зардлыг даатгагч хариуцна.

75.6.Зохицуулах хорооны зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагааны аливаа хэсгийг бусдад шилжүүлэх, эсхүл бусдын үйл ажиллагаатай нэгтгэх үр дагавар бүхий даатгагчийн байгуулсан хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

75.7.Зохицуулах хороо нь даатгалын үйл ажиллагааны аливаа хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх тухай гаргасан өргөдлийг нээлттэй хурлаар хэлэлцэж болох бөгөөд даатгагч болон бусад этгээдээс шаардлагатай нотлох баримт шаардаж болно.

АРВАНЗУРГАДУГААР БҮЛЭГ **Даатгагчийг татан буулгах**

76 дугаар зүйл. Даатгагчийн дампуурал

76.1.Даатгагчид дампуурлын хэрэг үүсгэхтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Дампуурлын тухай хуулийн дагуу зохицуулна.

76.2.Шүүх дараахь асуудлын талаар Зохицуулах хороонд мэдэгдэх бөгөөд Зохицуулах хороо уг асуудлыг хэлэлцэхэд оролцох, тайлбар өгөх эрхтэй:

76.2.1.Дампуурлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу даатгагчид дампуурлын хэрэг үүсгүүлэх тухай шүүхэд гаргасан нэхэмжлэл болон хүсэлт;

76.2.2.Дампуурлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу даатгагчид дампуурлын хэрэг үүсгэсэнтэй холбоотой гаргасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргаж буй аливаа гомдол;

76.2.3.даатгагчийн дампууралтай холбоотой Дампуурлын тухай хуулийн дагуу шүүхээс шийдвэрлэж буй бусад асуудал.

76.3.Даатгагчид дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргасан тохиолдолд Зохицуулах хороо Дампуурлын тухай хуулийн 5.7-д заасан хэрэг гүйцэтгэгчийг түр томилуулахаар хүсэлт гаргаж болох бөгөөд түүнд тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий хүнийг санал болгож болно.

76.4.Даатгагч дампуурсан тухайгаа зарласан тохиолдолд Зохицуулах хороо тохирох мэргэжил, дадлага туршлага бүхий хүнийг хэрэг гүйцэтгэгчээр томилуулахаар шүүхэд санал тавих бөгөөд энэ тохиолдолд Дампуурлын тухай хуулийн 8.2 дахь хэсэг үйлчлэхгүй.

76.5.Шүүх Зохицуулах хорооноос санал болгосон этгээдийг хэрэг гүйцэтгэгчээр томилж болно.

76.6.Хэрэг гүйцэтгэгч болон хэрэг гүйцэтгэгчээр түр томилогдсон этгээд нь Дампуурлын тухай хуулийн 11.2-т заасан шаардлагыг хангасан байхаас гадна даатгалын компанийн үйл ажиллагааны онцлогийн талаар зохих мэдлэгтэй байна.

76.7.Зохицуулах хороо нь Дампуурлын тухай хуулийн 8.3.3, 8.3.4, 8.3.6-д заасан асуудлаар шийдвэр гаргах эрхтэй.

76.8.Хэрэг гүйцэтгэгч нь өөрийн үйл ажиллагааны тухай Зохицуулах хорооны шаардлагатай гэж үзсэн мэдээлэл, тайланг гаргаж өгөх үүрэгтэй.

76.9.Зохицуулах хороо хариуцагч болон хэрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагааны талаар шүүхэд хэдийд ч гомдол гаргах эрхтэй.

76.10.Хариуцагч нь даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа бол Дампуурлын тухай хуульд заасан аливаа хугацааг шүүх өөрийн үзэмжээр сунгах эрхтэй.

77 дугаар зүйл. Даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх

77.1.Дампуурлын тухай хуулийн 23.1-д заасны дагуу даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх хүсэлт гаргаж байгаа, мөн хуулийн 24.1-д заасны дагуу даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг шүүхэд гаргаж буй этгээд нь уг хүсэлт, төлөвлөгөөний хуулбарыг Зохицуулах хороонд хүргүүлнэ.

77.2.Дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг хэлэлцэж буй нэхэмжлэгчдийн хуралд Зохицуулах хороо оролцож саналаа илэрхийлэх эрхтэй.

77.3.Шүүх даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг Зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр батлахгүй.

77.4.Шүүхээс даатгагчийг дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг батлах үйл ажиллагаанд Дампуурлын тухай хуулийн 28 дугаар зүйл үйлчлэхгүй.

78 дугаар зүйл. Даатгагчийг татан буулгах

78.1.Даатгагчийг татан буулгахтай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Иргэний хууль, Дампуурлын тухай хууль, Компанийн тухай хуулийн дагуу зохицуулна.

78.2.Даатгагчийг дараахь тохиолдолд татан буулгана:

78.2.1.шүүхийн шийдвэрээр;

78.2.2.Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрсөн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр.

/Энэ заалтад 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

78.3.Даатгагчийг татан буулгах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэр нь Зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр хүчин төгөлдөр бус байна.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

78.4.Энэ хуулийн 78.2-т зааснаас бусад тохиолдолд даатгагчийг татан буулгасан шийдвэр хүчин төгөлдөр бус байна.

78.5.Дараахь тохиолдолд Зохицуулах хороо даатгалын компанийг татан буулгах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргана:

78.5.1.даатгалын компани төлбөрийн чадваргүй болсон;

78.5.2.даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

78.6.Зохицуулах хороо тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа, эсхүл эрхэлж байсан хуулийн этгээдийг татан буулгуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.

78.7.Даатгагчийг татан буулгахаар нэхэмжлэл гаргасан тухай шүүх Зохицуулах хороонд мэдэгдэх бөгөөд Зохицуулах хороо нэхэмжлэлтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэхэд оролцох, тайлбар өгөх эрхтэй.

78.8.Дампуурлын тухай хуулийн дагуу даатгагчийг татан буулгахад шүүх хяналт тавих бөгөөд Дампуурлын тухай хуулийн 38.1 дэх хэсэг үйлчлэхгүй.

79 дүгээр зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах

/Энэ зүйлийн гэрчигт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

79.1.Энэ хуулийн 78.2.2-т заасны дагуу гаргасан хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах тухай өргөдөлд татан буулгах комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээдийн нэрсийн жагсаалтыг хавсаргана.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

79.2.Зохицуулах хороо хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр даатгагчийг татан буулгах зөвшөөрлийг дараахь тохиолдолд олгохгүй:

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

79.2.1.даатгагчийн хөрөнгийн нийт үнэлгээнээс түүний хүлээсэн үүргийг хасаж үлдсэн хэсэг нь энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн доод хэмжээг хангахгүй;

79.2.2.татан буулгах комиссын гишүүнээр томилуулахаар санал болгож буй этгээд нь ийнхүү ажиллахад шаардлагатай ур чадвар, дадлага туршлагагүй.

79.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас даатгагчийг татан буулгах тухай тогтоолыг батлахдаа татан буулгах комиссыг томилно.

/Энэ хэсэгт 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

79.4.Татан буулгах комисс томилогдсон тухайгаа тогтоолд заасан хугацаанд Зохицуулах хороонд мэдэгдэх үүрэгтэй.

79.5.Татан буулгах комиссын эрх хэмжээг Зохицуулах хорооноос холбогдох хуульд нийцүүлэн тогтооно.

80 дугаар зүйл. Даатгагчийн урт хугацааны сан

80.1.Урт хугацааны даатгагч нь удаан хугацаагаар тогтвортой үйл ажиллагаа эрхлэх үүднээс урт хугацааны сан бүрдүүлнэ.

80.2.Урт хугацааны даатгагч Дампуурлын тухай хууль болон бусад хуулийн дагуу татан буугдахад даатгагчийн урт хугацааны санг зөвхөн энэ хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу зарцуулна.

80.3.Даатгагчийн урт хугацааны сан нь тус санд хамаарах даатгагчийн урт хугацаат үүргийн гүйцэтгэлийг хангахад зарцуулагдах бөгөөд энэ хэмжээгээрээ даатгагчийн хуваарилагдах хөрөнгө гэж тооцогдохгүй.

80.4.Энэ хуулийн 80.3-т заасны дагуу зарцуулсны дараа үлдсэн хөрөнгийг Иргэний хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу даатгагчийн хуваарилагдах хөрөнгө гэж тооцож болно.

АРВАНДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад

81 дүгээр зүйл. Мэдээллийн нууцлалыг хадгалах

81.1.Зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтан нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь этгээдтэй холбоотой аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно:

81.1.1.тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасан этгээд;

81.1.2.даатгагч, эсхүл даатгагч байсан этгээд, тэдгээрийн хараат болон охин компани;

81.1.3.даатгуулагч, эсхүл даатгуулагч байсан этгээд.

81.2.Дараахь тохиолдолд энэ хуулийн 81.1 дэх хэсэг хамаарахгүй:

81.2.1.тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

81.2.2.Зохицуулах хороо шаардсан;

81.2.3.шүүх болон прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын шаардлагаар тэдгээр байгууллагын удирдлага хүсэлт гаргасан;

81.2.4.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тухайн этгээд мэдэх шаардлагатай;

81.2.5.уг мэдээллийг олон нийт бусад эх сурвалжаас мэдэх боломжтой, эсхүл нэгэнт мэдээлэгдсэн;

81.2.6.тухайн мэдээлэлтэй холбогдох энэ хуулийн 81.1-д заасан этгээдийг таних боломжгүй байдлаар буюу мэдээллийг товчлол, эсхүл статистик тоо баримтаар мэдээлэх;

81.2.7.энэ хуулийн 66 дугаар зүйлд заасны дагуу гадаадын зохицуулах байгууллага бичгээр хүсэлт гаргасан.

82 дугаар зүйл.Зохицуулах хорооны шийдвэрийг давж заалдах

82.1.Аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдаж болно.

82.2.Зохицуулах хорооны шийдвэрийг давж заалдсан нь хариуцлага хүлээлгэх шийдвэрийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй бөгөөд даатгагчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг шийдвэрлэхэд Захиргааны хариуцлагын тухай хуулийн 19.2, 19.3 дахь хэсэг хамаарахгүй.

83 дугаар зүйл. Даатгалын тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

83.1. Даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол даатгалын хяналтын улсын байцаагч гэм буруутай этгээдэд дараахь хариуцлага ногдуулна:

/Энэ хэсэгт 2010 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

83.1.1. тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бусаар олсон орлогыг хурааж 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.2. энэ хуулийн 17.2-т заасны дагуу Зохицуулах хорооны зөвшөөрөлгүй гадаад улсын даатгагчтай даатгалын гэрээ байгуулсан иргэнийг 10000-25000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.3. энэ хуулийн 21.1, 21.2-т заасны дагуу Зохицуулах хорооны зөвшөөрөлгүй өөрийн эзэмшиж буй хөрөнгийг бусдад шилжүүлсэн буюу өөртөө шилжүүлэн авсан, эсхүл энэ хуулийн 21.3-ыг зөрчсөн бол 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.4. энэ хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу дүрмийн сангийн доод хэмжээг бүрдүүлээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.5. энэ хуулийн 23.1-д заасны дагуу даатгагчаас гаргаж буй хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр гүйцэтгэсэн бол 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.6. энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг дагаж мөрдөөгүй бол даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.7. энэ хуулийн 25.2-т заасны дагуу нөөц санг бүрдүүлээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.8. энэ хуулийн 26 дугаар зүйлд заасныг зөрчиж ногдол ашиг хуваарилсан, эсхүл хуваарилахаар зарласан даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.9. энэ хуулийн 27 дугаар зүйлд заасныг зөрчсөн албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.10. энэ хуулийн 29.2, 29.6, 67.1.8-д заасныг зөрчиж нягтлан бодох болон санхүүгийн бүртгэлээ зохих ёсоор хөтлөөгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.11. энэ хуулийн 33.2-т заасны зөрчиж аудиторыг томилсон бол албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.12. энэ хуулийн 36.1, 36.2-т заасан үүргээ биелүүлээгүй аудиторыг 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.13. энэ хуулийн 38.1, 42.3-т заасны дагуу Зохицуулах хорооноос тавьсан шаардлагыг биелүүлээгүй албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-100000 төгрөгөөр торгох;

83.1.14. энэ хуулийн 39.1-д заасныг зөрчиж актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээд актуарчаар ажилласан бол хууль бусаар олсон орлогыг хурааж 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.15. энэ хуулийн 40 дугаар зүйлд заасны дагуу өөрийн актуарчийг томилоогүй, эсхүл энэ хуулийн 42.1-д заасны дагуу актуарын хяналт шалгалт хийлгээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.16. энэ хуулийн 41, 44 дүгээр зүйлд заасан үүргээ биелүүлээгүй актуарчийг 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.17. энэ хуулийн 47.1, 50 дугаар зүйлд заасны дагуу давхар даатгалын болон бизнес төлөвлөгөөг батлуулаагүй, эсхүл эдгээр төлөвлөгөөг дагаж мөрдөх үүргээ биелүүлээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.18. энэ хуулийн 48.1-д заасны дагуу давхар даатгалын төлөвлөгөөний нарийвчилсан тайланг гаргаж өгөөгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.19. энэ хуулийн 49 дүгээр зүйлд заасныг зөрчиж даатгалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоогүй үйл ажиллагаа эрхэлсэн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.20. энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасныг зөрчсөн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.21. энэ хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу даатгагчийн оршин байгаа газрын хаяг болон түүний өөрчлөлтийг мэдэгдээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.22. энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасан салбар, төлөөлөгчийн газар нээхтэй холбогдсон журмыг зөрчсөн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.23. энэ хуулийн 55.1-д заасныг зөрчиж Зохицуулах хорооны зөвшөөрөлгүйгээр эрх бүхий албан тушаалтныг томилсон бол албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.24. энэ хуулийн 60 дугаар зүйлд заасан нэр ашиглах журмыг зөрчсөн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.25.энэ хуулийн 63 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй холбогдох этгээдийг 500000-1000000 төгрөгөөр, албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр торгох;

83.1.26.энэ хуулийн 64.3-т заасан үүргээ биелүүлээгүй холбогдох этгээдийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.27.энэ хуулийн 65.6-т заасан мэдэгдлийг биелүүлээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.28.энэ хуулийн 71.1-д заасныг зөрчиж шинээр даатгалын гэрээ байгуулсан, даатгалын гэрээнд өөрчлөлт оруулсан даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.29.энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу Зохицуулах хорооноос өгсөн даалгаврыг биелүүлээгүй албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.30.энэ хуулийн 75.1-д заасныг зөрчиж Зохицуулах хорооноос зөвшөөрөл авалгүйгээр даатгалын үйл ажиллагааг шилжүүлсэн, нэгтгэсэн даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.31.энэ хуулийн 22.4, 24.4, 25.4, 40.2, 55.3, 57 дугаар зүйлд заасны дагуу Зохицуулах хороонд мэдэгдээгүй даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.32.даатгалын тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар Зохицуулах хорооны гаргасан шийдвэрийг биелүүлээгүй ажилтан, албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, даатгагчийг 500000-1000000 төгрөгөөр торгох;

83.1.33.хуулиар тогтоосон албан журмын даатгалд даатгуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-150000 төгрөгөөр, иргэнийг 5000-20000 төгрөгөөр торгох.

/Энэ заалтад 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

84 дүгээр зүйл. Зохицуулах хорооны албан хаагчийн хязгаарлагдмал хариуцлага

84.1.Зохицуулах хорооны албан хаагч энэ хууль, холбогдох бусад хууль болон даатгалын багц дүрэмд заасан үүргээ шударга бусаар хэрэгжүүлсэн буюу санаатайгаар хэрэгжүүлээгүй болох нь тогтоогдсоноос бусад тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

85 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

85.1.Энэ хуулийг 2005 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

/Энэ хэсэгт 2004. оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

85.2.Энэ хуулийн даатгалын компанийн дүрмийн сангийн хэмжээг заасан 22.1 дэх хэсгийг 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.